



## ШИНЖЭЭЧИЙН ТАЙЛАН

**Байгууллагын нэр:** ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛЬ, ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

**Хөтөлбөрийн нэр:** ЭРХ ЗҮЙ

**Индекс:** D042101

**Шинжээчийн баг:**

Ахлагч: А.Доржготов

Гишүүд: Г.Буянтогтох

Ч.Жаргалсайхан

Улаанбаатар хот

2020 он

## **АГУУЛГА**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР**

ААНЭЗ – Аж ахуй нэгжийн эрх зүй  
АНУ – Америкийн нэгдсэн улс  
ББСБ – Банк бус санхүүгийн байгууллага  
БЗД – Баянзүрх дүүрэг  
БНСУ – Бүгд найрамдах Солонгос улс  
БНХАУ - Бүгд найрамдах Хятад ард улс  
БНТУ – Бүгд найрамдах Турк улс  
БМИҮЗ – Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл  
БСШУСЯ – Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам  
БШУЯ – Боловсрол, шинжлэх ухааны яам  
ЗХШҮА – Захиргаа хяналт, шинжилгээ, үнэлгээний алба  
МИДСК – Монголын их, дээд сургуулийн консерциум  
МНТ – Монголын наториатын танхим  
МӨХ – Монголын өмгөөлөгчдийн холбоо  
МУГЕГ – Монгол Улсын Гаалийн ерөнхий газар  
МХХ – Монголын хуульчдын холбоо  
ОТДС – Отгонтэнгэр дээд сургууль  
ОТИС – Отгонтэнгэр их сургууль  
ОУЭЗ – Олон улсын эрх зүй  
ОХУ – Оросын холбооны улс  
ӨМӨЗО – Өвөр Монголын өөртөө засах орон  
СБД – Сүхбаатар дүүрэг  
УЗ – Удирдах зөвлөл  
ҮХЦ – Үндсэн хуулийн цэц  
ХБНГУ – Холбооны бүгд найрамдах Герман улс  
ХИДСХ – Хувийн их, дээд сургуулиудын холбоо  
ХЗДХЯ – Хууль зүй, дотоод хэргийн яам  
ХЗС – Хууль зүйн сургууль  
ХЗКСТ – Хууль зүйн клиник сургалтын төв  
ХХК – Хязгаарлагдмал хариуцлагатай компани  
ХХН – Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл  
ЭШСТ – Эрдэм шинжилгээ, судалгааны төв  
ЭШХ – Эрдэм шинжилгээний хурал

## I. ХӨНДЛӨНГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ, ТӨЛӨВЛӨЛТ

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Отгонтэнгэр Их Сургууль / Otgontenger University		
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Эрх зүй / Law		
<b>Индекс</b>	D042101		
<b>Шинжээчид</b>	1. А.Доржготов /Шихихутуг их сургуулийн Иргэн, бизнесийн эрх зүйн багш, МХХ-ны гишүүн / 2. Г.Буянтогтох /Дотоод хэргийн их сургуулийн Багшийн хөгжлийн төвийн эрхлэгч/ 3. Ч.Жаргалсайхан /МУГЕГ-ын Хэвлэл мэдээлэл, сургалт судалгааны төвийн багш, Гаалийн улсын ахлах байцаагч/		
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	П. Оргилмаа /БМИҮЗ-ийн Ажлын албаны магадлан итгэмжлэл хариуцсан мэргэжилтэн/		
<b>Төлөвлөгөө, хэрэгжилт</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>	
	2019 оны 12 сарын 26	1. Шинжээчдийн баг өглөө 08.40-д ОТИС-ийн Удирдлагуудтай уулзалт хийсэн. 2. Хөтөлбөрийн танилцуулгыг ХЗС-ийн захирал С.Эрдэнэчимэг танилцуулав. 3. Хөтөлбөрт хамаарах материаллаг баазтай танилцсан. 4. Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой танилцаж нэмэлт тодруулга авсан. 5. Өөрийн үнэлгээний багийнхантай уулзалт хийсэн. 6. Хөтөлбөрт хичээл ордог багш нартай уулзалт хийсэн.	
	2019 оны 12 сарын 27	1. Шинжээчдийн баг өглөө 08.40-өөс цуглан дотоод ажлаа төлөвлөж 09.00 цагаас ажил олгочдын төлөөлөлтэй уулзсан. 2. 10.30-аас төгсөгчдийн төлөөлөлтэй уулзалт хийсэн 3. 11.30-12.30 оюутнуудтай уулзалт хийсэн. Нотлох баримттай холбоотой нэмэлт тодруулга авсан. 4. 13.30-14.30 Нотлох баримтуудтай танилцсан. 5. 14.30-16.00 Шинжээчид үнэлгээний ажлаа хэлэлцэж, дүгнэлт гаргасан. 6. 16.00-17.00 Шинжээчид үнэлгээний дүгнэлтийг өөрийн үнэлгээний багийнханд танилцуулав.	
	<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар тогтоолоор батлагдсан “Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагын дагуу ажиллав.	

## II. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН ТАНИЛЦУУЛГА

Отгонтэнгэр их сургууль нь 1991 онд хувийн хэвшлийн дээд сургуулийн статустайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд Гэгээрлийн сайдын 103 дугаар тушаалаар батлагдсан тусгай зөвшөөрлийн үндсэн дээр 1994 оноос “Олон улсын эрх зүй” мэргэжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр 1995 онд үндсэн 7 багштайгаар Эрх зүйн тэнхим байгуулагдсан. Улмаар 2005-2006 оны хичээлийн жилд ОТИС-ийн бүтцийн 3-н сургуулийн нэг болж “Хууль зүйн сургууль” нэртэйгээр зохион байгуулагдан эрх зүйн байдал бүтцийн хувьд өөрчлөгдөж эдүгээ хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

1999 онд Монгол Улсад магадлан итгэмжлэгдсэн анхны дээд сургууль болж улмаар “Их сургууль”-ийн статустай болсноор Эрх зүйн магистр, докторын зэргийн сургалт явуулах зөвшөөрөл авсан байна. 2004 онд 2 дахь, 2018 онд байгууллагын гурав дахь магадлан итгэмжлэлд амжилттай орсон.

Нийгмийн хөгжлийн тухайн үеийн эрэлт хэрэгцээ, шаардлагын үүднээс Шинжлэх ухаан боловсролын сайдын 1996 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 84 дүгээр тушаалаар Эрх зүй (D380100) мэргэжлээр Эрх зүй (аж ахуйн-D380103), Эрх зүй (олон улсын D380106) мэргэжлээр өдөр, орой, эчнээ сургалт явуулах тусгай зөвшөөрөл авч 1996 оноос сургалт явуулж эхэлсэн байна. Түүнчлэн 1997 оноос Хууль зүйн яамны захиалгаар хуулийн дунд сургууль төгссөн хүмүүсийг бакалаврын боловсролтой болгох зорилгоор “Хуулийн зөвлөх-өмгөөлөгч” мэргэжлийн эчнээ анги нээн сургалт явуулжээ. 2014 онд “Олон улсын эрх зүй”, “Аж ахуйн эрх зүй”-н сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлж 141, 142 тоот гэрчилгээ авсан байна.

**ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙН АЛСЫН ХАРАА:** Сургалтын хөтөлбөрийг шинэчилж, мэргэжлийн хичээл заах мэргэшсэн багш нарын тоог нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн, зөв хандлагатай мэргэжилтэн бэлтгэдэг орчин үеийн шилдэг Хууль зүйн сургууль болох **ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО:** Нийгмийн хэрэгцээ шаардлага, боловсролын стандартад нийцэхүйц хууль зүйн мэргэжлийн болон гадаад хэлний зохих мэдлэгтэй, ёс зүйн өндөр соёлтой мэргэжилтэн бэлтгэнэ.

## III. ШИНЖЭЭЧИЙН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

### Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

*Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу ижэ бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.*

#### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Эрх зүй бакалаврын хөтөлбөрийг боловсруулахдаа боловсрол, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/285, А/174, А/78 дугаар тушаалууд, стандартчилал, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөс баталсан “ Эрх зүйн бакалаврын боловсролын стандарт, ОТИС-ийн 2013-2022 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө, үндсэн чиглэл, ОТИС-ийн болон ОТИС-ийн ХЗС-ийн эрхэм зорилго зэрэг бодлогын баримт бичгүүдийг удирдлага болгон мэргэжлийн индекс, нэршил өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Олон улсын эрх зүй, Аж ахуйн нэгжийн эрх зүй хөтөлбөрүүдийг нэгтгэн шинэчилж, 2014 онд “Эрх зүй” D042101 бакалаврын хөтөлбөрийг боловсруулж батлуулан мөрдөж эхэлсэн байна.”
- Эрх зүй бакалаврын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр ОТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан хөтөлбөрийн дэд хороо 2014, 2016, 2017, 2019 онуудад

бүрэлдэхүүнд өөрчлөлт оржээ. Нийт 8 удаа хуралдаж сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртөө 2014, 2017, 2018, 2019 онуудад нэмэлт өөрчлөлт оруулж ирсний зэрэгцээ эрх зүй мэргэжилтний загвар, орчин үеийн нийгмийн эрэлт хэрэгцээ, хууль зүйн салбарын шинэчлэлтэй уялдуулан эрх зүй бакалаврын хөтөлбөрийн зорилгоо шинэчлэн сургалтын төлөвлөгөөндөө шинэлэг хичээлүүдийг тусган хэрэгжүүлжээ. Тухайлбал, эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа, зөрчлийн эрх зүй, захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гэх мэт.

- Түүнчлэн ажил олгогч 7 байгууллагаас төгсөгчдийнхөө талаар сэтгэл ханамжийн судалгааг 10 багц асуудлаар авч, төгсөгчдийн төлөөлөлтэй фокус ярилцлага хийж, хөтөлбөрийг сайжруулах чиглэлээр санал асуулга явуулж хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулахад харгалзан үзэж 2019 оны 04 сард Эрдмийн зөвлөлийн хурлаар эрх зүй бакалаврын хөтөлбөрөө шинэчлэн батлуулж 2019-2020 оны хичээлийн жилээс мөрдөж эхэлжээ.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

Эрх зүй мэргэжилтний загвар, орчин үеийн нийгмийн эрэлт хэрэгцээ, хууль зүйн салбарын шинэчлэлтэй уялдуулан эрх зүй бакалаврын хөтөлбөрийн зорилгоо шинэчлэн сургалтын төлөвлөгөөндөө шинэлэг хичээлүүдийг тусган хэрэгжүүлжээ.

Клиник сургалтын хөтөлбөрөөрөө загвар сургууль болсон

Бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэх тал дээр түлхүү анхаардаг

Зөрчлийн эрх зүй, захиргааны шийдвэр гаргах ажиллагааны эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа гэх мэт хичээлүүдийг нэмж тусгасан.

#### **Анхаарах асуудал:**

- Клиник сургалтад хамрагдах оюутнуудыг төлбөрийн чадваргүй иргэдэд зөвлөх, туслах ажлын хүрээг өргөтгөх

#### **Зөвлөмж:**

- Эрх зүй бакалаврын хөтөлбөрийг боловсруулахдаа бодлогын баримт бичгүүдийг удирдлага болгон боловсруулж батлуулан мөрдөж эхэлсэн байна. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ямар хэрэгцээ, шаардлага байгааг /үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлага/ тодорхой, энгийн томъёолох хэрэгтэй байна.

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Эрх зүй D042101 бакалаврын хөтөлбөрийн зорилгоо тодорхойлохдоо ОТИС-ийн болон ХЗС-ийн эрхэм зорилго, ОТИС-ийн алсын хараа, бодлогын баримт бичгүүдийг удирдлага болгон хөтөлбөрийн зорилгоо 2014 онд тодорхойлсон бөгөөд 2017 онд шинэчлэн батлуулсан байна. Сургалтын хөтөлбөр нь зорилгодоо нийцэж байна.
- Хөтөлбөрийг шинэчлэхдээ ажил олгогч, суралцагч, төгсөгчдийн төлөөллийг хөтөлбөрийн дэд хорооны хуралдаанд урьж оролцуулан тэдгээрийн саналыг тусгаж, сонирхлын бүлгүүдээс авсан судалгааг харгалзан үздэг болох нь хөтөлбөрийн дэд хорооны хуралдааны тэмдэглэл, судалгааны материалуудаар нотлогдож байна.
- Хөтөлбөрийн өөрчлөлт шинэчлэлийн талаар сонирхлын бүлгүүд болон олон нийтэд дараах сайт, номын сан, бие даалтын болон клиник сургалтын төв зэрэг олон хэлбэрээр ил тод мэдээлдэг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Клиник дадлагын багц хичээлийг оюутан бүр заавал сонгон суралцдаг болсноор хуульчийн болон эрх зүйн боловсрол шаардагдах ажил, мэргэжлийн дадал, чадвар эзэмшүүлэхэд хөтөлбөрийн зорилго чиглэгдэх болсон.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн зорилгыг улам тодруулж өргөн хүрээтэй болгох
- Эдийн засгийн суурь мэдлэгийг илүүтэйгээр, улам түлхүү олгох тал дээр онцгойлон анхаарах

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн өнөөгийн түвшинд байгаа чанар, үр дүн, ач холбогдлыг бууруулахгүй байх.
- Төрийн албан хаагчийн ёс зүйг хэрхэн төлөвшүүлэх талаар зорилгодоо тусгах
- Боловсролын шинэчлэлийн чиг хандлагатай нийцүүлэн суралцагч төвтэй талаас зорилгодоо тусгах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Эрх зүй бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөг 2014, 2017, 2019 онуудад шинэчлэн боловсруулж, хэлэлцсэн нь хөтөлбөрийн дэд хорооны хуралдааны болон сургуулийн эрдмийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэлүүдээр нотлогдож байна.
- 2019 оны 04 сарын 11-ний өдрийн эрдмийн зөвлөлийн хурлаар батлагдсан “Эрх зүй” бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан нийт мэргэжлийн суурь, мэргэжлийн, мэргэшүүлэх чиглэлийн 56 хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн, батлагдсан загварын дагуу боловсруулж, тэнхимийн болон ХЗС-ийн багш нарын өргөтгөсөн хурал, хөтөлбөрийн дэд хорооны хурлуудаар шат дараалан хэлэлцүүлж ОТИС-ийн захирлаар батлуулан мөрдөж байна.
- Хичээлийн шинэчилсэн хөтөлбөрийн бүтцэд хичээлээр хүрэх үр дүн гэсэн үзүүлэлт болон 9 баллын үнэлгээний системийг нэмж тусгасан байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эрх зүй хөтөлбөрөөр суралцдаг нийт оюутнуудыг I ангиас нь OXFORD-ын англи хэлний сургалтад хамруулдаг болсон.
- Багш нараа 2018 оноос вакумжуулсан англи хэлний сургалтанд хамруулж эхэлсэн ба залуу багш нараа OXFORD-ын сургалтанд хамруулж, туршилтаар англи хэл дээр хичээл заалгах ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн хөтөлбөрүүдийг төлөвлөхдөө хөтөлбөр тус бүрт дүгнэлт хийж хичээлийн уялдаа холбоонд анхаарч хууль эрх зүйн салбарт өнөө үед зайлшгүй хэрэгцээтэй шинэлэг санаа, оновчтой зүйлүүдийг түлхүү тусгах
- Хичээлийн тодорхойлолт, агуулга, заах арга зүйг шинэлэг болгож улам нарийвчлан авч үзэж, дэлгэрүүлэх, нэн тэргүүнд зайлшгүй шаардлагатай додоодын болон гадаадын сургалтанд түлхүү хэрэглэгдэж буй орчин үеийн элементүүдийг тусгах

#### **Зөвлөмж**

- Хөтөлбөрийн төлөвлөлтийн бичиг баримтуудыг тусгайлан авч үзэж архивын баримт хэлбэрээр хадгалдаг болох
- Төгсөлтийн дараах ахисан түвшний болон давтан сургалтын цар хүрээг улам нэмэгдүүлж эргэх холбоог сайжруулах
- Онлайн сургалтыг төлөвлөхөд түлхүү анхаарах

**1-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

*Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.*

### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

1. Сургалтын бүх үйл явцад олон улсын стандартын арга зүйн тулгуур буюу PDCA /Plan-Do-Check-Act/ мөчлөг болох “Төлөвлө-хий-шалга-сайжруул” гэдэг арга зүйг хэрэглэж байгаатай уялдуулж сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагнах, хэлэлцэх, ажлын зохион байгуулалтад өөрчлөлт хийсэн байна.
2. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001-2015 олон улсын стандартыг нэвтрүүлэн баталгаажуулсан нь боловсролын салбар дахь анхны их сургуулийн нэг болжээ.
3. ОТИС-д мөрдөгдөж буй эрх зүйн актуудад хяналт шинжилгээ хийгдэж 2019 онд тус сургуулийн эрх зүйн баримт бичгийн шинэчлэл хийгдсэн нь дээд боловсролын чанар стандартад нийцүүлэн сургалтын тогтвортой үйл ажиллагаа явагдах эрх зүйн орчин бүрдсэн /ОТИС-ийн эрх зүйн баримт бичгийн 3 дахь удаагийн эмхэтгэл 2019 онд хэвлэгдсэн/ байна.
4. ОТИС-ийн ХЗС нь үндэсний хэмжээнд эрх зүйн боловсролын шинэтгэлийн төслийг хэрэгжүүлэн түшиц сургууль болж, баг хамт олноороо ажилласан байна.
5. Бакалаврын хөтөлбөрийн агуулгатай уялдуулан багц цагийн бүрэлдэхүүн, багц цагийн харьцаа өөрчлөгдсөн. Энэхүү өөрчлөлтөөр мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлийн заавал болон сонгон судлах хичээлүүдийн агуулга, тэдгээрийн залгамж холбоо, мэргэших чиглэлээр нарийвчлан судлах чиглэл зэргийг харгалзан үзэж багц цагийн бүрэлдэхүүнд хамаарах хичээлүүдэд зарим өөрчлөлт орсон байна.
6. “Эрх зүй” хөтөлбөрийн хичээлийн хэлбэр нь лекц, семинар, дадлага гэсэн 3 хэлбэртэй байна. Лекцийн хичээлийн хүрээнд тухайн шинжлэх ухааны онолын мэдлэг, семинарын хичээлийн хүрээнд нэгж хичээлийн хөтөлбөрт тусгагдсан бие даалтын ажил хийх, эссэ бичих, кейс шинжлэх, баримт материалд шинжилгээ хийх мэтгэлцэх, дүрд тоглох, баримт бичиг боловсруулах зэргээр онолын мэдлэгээ бататгаж практикт хэрэглэх ур чадварыг олгоход чиглэж байна. Харин клиник дадлага болон хуульч мэргэжлийн дадлага, хууль тогтоомжийн хэрэглээний хичээлийн хүрээнд нэгж хичээлийн хөтөлбөр болон удирдамжид заасан мэдлэг, ур чадваруудыг олгоход чиглэгдэж байна. Үүнтэй уялдаж бие даалтын цаг нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
7. Эрх зүйн мэргэжлээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаа нь хөтөлбөрт тусгагдсан хичээл хоорондын залгамж, мэргэжилтний загварын холбоо хамаарал нийцлийг хангахад чиглүүлж сургалтын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгийн системчлэлийг сайжруулан хөтөлбөрийг боловсруулсны үр дүн гэж үзэж байна. Мөн мэргэжлийн суурь хичээлүүдийн хувьд суралцагсдад онолын мэдлэг, ур



чадвараас гадна хувь хүний төлөвшил хандлага, харин мэргэжлийн хичээлийн хувьд онолын мэдлэгээс илүү чадвар дадал олгоход чиглэгдэж байна. Энэ нь “Эрх зүй” хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлүүдээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, ур чадвар, хандлагатай уялдаж сургалтын агуулга хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байгаагийн нэг илрэл гэж дүгнэж байна.

8. Эрх зүйн бакалаврын сургалтын хүрээнд оюутан танхимд олж авсан онолын мэдлэгээ практикт хэрэглэх, эрх зүйн болон хуульчийн мэргэжлийн ажлын ур чадварт суралцан, зохих дадал чадваруудыг эзэмших хэрэгцээ шаардлагыг харгалзан тус сургуулийн Хууль зүйн клиник сургалтын төв нь эрх зүйн сургалтын үндсэн нэгж болон тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

9. Хууль зүйн клиник сургалтын үр дүнг тасралтгүй дээшлүүлэх, хөгжүүлэх бодлогыг барьж ажиллаж байна. Үүний нэг тод жишээ бол 2019 оны сургалтын төлөвлөгөөнд орсон өөрчлөлт, шинэчлэлт харуулж байна. Сургалтын төлөвлөгөөгөөр (Сургалтын явцын “В” клиник дадлагын хичээлийн төлөвлөгөөнд) хууль зүйн клиникийн хүрээнд үзэх хичээлүүдийн залгамж холбоо, хамаарлыг харгалзан хичээлийн хүрэх үр дүнтэй уялдуулан, тэдгээрийг төрөлжүүлэн багцлан системчлэх сайжруулалт хийгдсэн явдал юм. Тухайлбал:

Хууль зүйн клиник 1. Мэргэжлийн ур чадвар

Хууль зүйн клиник 2. Хууль зүйн баримт бичиг боловсруулах арга зүй

Хууль зүйн клиник 3. Хуульчийн мэргэжлийн ур чадвар

Хууль зүйн клиник 4. Шүүхийн мэтгэлцээн

Хууль зүйн клиник 5. Сонгон клиник гэсэн 5 блок буюу багцын хүрээнд 20 хичээлийн агуулгыг багтаасан нь мэргэжлийн хэрэгцээ шаардлага болон эрх зүйн шинэтгэлийн бодлоготой нийцүүлсэн өөрчлөлт бөгөөд ингэснээр оюутнууд тухайн багцын хичээлүүдэд бүрэн хамрагдах, мөн мэргэших чиглэлээрээ сонгон судлах боломжтой болсон байна.

10. Хууль зүйн сургууль нь танхимын болон хууль зүйн клиник сургалтын хичээлээс гадна суралцагчдыг чадваржуулах нэмэлт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд хөдөлмөрийн зах зээлд нэн шаардлагатай эрэлттэй байгаа мэргэжилтний ажлын байрны шаардлагад нийцсэн мэргэжилтэн хөтөлбөрийн хүрээнд үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааг өргөжүүлэх бодлогыг баримтлан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах түншлэлийн харилцаагаа өргөжүүлэх санамж бичиг, хамтран ажиллах гэрээ байгуулан, төсөл хөтөлбөр хэрэгжүүлж сайн дурын ажилтан, зөвлөх ажилтнаар ажиллуулах, хууль зүйн зөвлөгөө өгөх, хууль сурталчлах, төсөл судалгааны болон мэтгэлцээний багш, оюутны баг бүрдүүлэн ажиллах зэрэг хэлбэрүүдээр “Багш-Оюутан”, “Оюутан-Оюутны”, “Практик ажилтан-оюутны” хамтын түншлэлийн харилцааны хүрээнд олон талт ажлуудыг зохион явуулжээ. Сургалтын нэмэлт хөтөлбөрүүдээс товч дурдвал:

- Бизнесийн дэмжлэг
- Оюутны оролцоо-Манлайлал
- Илтгэх ур чадвар
- Мэтгэлцэх ур чадвар
- Эвлэрүүлэн зуучлагчийн ур чадвар
- УИХ-ийн гишүүний туслах, бие төлөөлөгч бэлтгэх
- Хүний эрхийн сургагч багш
- Үе тэнгийн сургагч багш
- Жендерт суурилсан хүчирхийллийг зогсоох, хохирогч хамгаалал
- Нийтийн эрх ашгийг хамгаалах сургалт
- Шударга ёсны төлөө хамтдаа
- Хүний эрхийн боловсрол олгох гэх мэт хөтөлбөрүүд.

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/туршлага**

1. 2014-2015 оны хичээлийн жилд Нээлттэй нийгэм форумоос гаргасан “Хууль зүйн клиник сургалт”-ын стандартын хэрэгжилтийн мониторингийн тайлан (улсын болон хувийн хуулийн их дээд сургууль 10)-д **Клиник сургалтын үйл ажиллагааны зохион байгуулалтын болон сургалтын тусгай хөтөлбөрийн хүрээнд сайн туршлага хуримтлуулж бусад их дээд сургуулийг манлайлан ажиллаж буй сургуулийн жишээнд ОТИС-ийн ХЗС-ийг нэрлэж болох байна** гэсэн дүгнэлт хийсэн байна.
2. ХЗС нь 2005 оноос эхлэн мэтгэлцээний чиглэлээр зохион байгуулалтын ажлуудыг явуулж эхэлсэн бөгөөд энэ хугацаанд мэтгэлцээний сургалтын арга зүй, зохион байгуулалтын сайн туршлагыг хуримтлуулж, мэтгэлцээний чадвар эзэмшсэн багш, оюутан, төгсөгчдийн багийг бүрдүүлж амжилттай ажиллаж үйл ажиллагаа нь өргөжин тэлж 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн Мэтгэлцээний үндэсний хөтөлбөр боловсруулан БСШУЯ, МНТ-тай хамтран үндэсний хэмжээнд хэрэгжүүлэх мэтгэлцээний үндэсний сургууль болон ажиллаж өргөн цар хүрээтэй ажлуудыг их дээд сургуулийн оюутан, ЕБС-ийн сурагчид, багш, нийгмийн ажилтнуудыг хамруулан зохион байгуулдаг болжээ.
3. 2014-2016 онуудад Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага Жайкагийн эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төслийн хүрээнд “Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлалын журмаар шийдвэрлэх ажиллагаа” хичээлийн хөтөлбөр, гарын авлага боловсруулан, туршиж хуулийн их дээд сургуулиудын багш, удирдлагууд, эвлэрүүлэн зуучлагч нарын хүрээнд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулан, ЭШХ-д илтгэл хэлэлцүүлэх, гадаадад мэргэжил дээшлүүлж, туршлага судлах, эвлэрүүлэн зуучлагчийн эрх авах сургалт, сонгон шалгаруулалтад багш, төгсөгч оюутныг хамруулах, бакалаврын төдийгүй ахисан түвшний сургалт явуулах, магистрын диплом хамгаалах зэрэг олон талт ажлууд хийгдэж түшиц сургууль болж ажилласан байна.
4. 2015 оноос эхлэн Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороотой хамтран ажиллах гэрээ байгуулж компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд Компанийн засаглалын сургалт явуулах түшиц сургууль болон ажиллах боломжтой болжээ.
5. Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001-2015 олон улсын стандартыг нэвтрүүлэн баталгаажуулсан.
6. Клиник сургалтын төвөөс гадна клиник дадлагын хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнд тусган нийт оюутнуудыг хамруулан ур чадвар олгодог

### **Анхаарах асуудал:**

- Боловсруулсан хөтөлбөрүүдийг үзэхэд үг үсэг, техникийн алдаа ажиглагдсан .
- Эрх зүйн хөтөлбөр хэрэгжүүлдэг бусад сургуулиудын шинэлэг болон тэргүүн туршлагыг судалж хөтөлбөртөө зохих ёсоор тусгаж байх
- Мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи аль болох түлхүү ашиглах

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Нэгж хичээлийн хөтөлбөр (шинэчлэгдсэн)
- Эрх зүйн хөтөлбөрийн хичээлийн заах арга зүйн матриц
- Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамж (Монголын Хуульчдын Холбоо, Хуульчийн мэргэжлийн асуудал эрхэлсэн шалгалтын хороо 2018)
- Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн төгсөлтийн шалгалтын журам 2019
- Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн зүйн сургуулийн нэгдсэн шалгалтын бодлого, шалгалтын ажлыг шалгах загварчлал хуудас (2018, 2019)
- Хууль тогтоомжийн хэрэглээ гарын авлага

- Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх арга зүйн зөвлөмж (Шүүх судалгаа, мэдээлэл сургалтын хүрээлэн)
- Skills of debate - Мэтгэлцээний сурагч, дасгалжуулагч багш нарт зориулсан гарын авлага (2016, 2017, 2018, 2019 он)
- Отгонтэнгэр их сургуулийн сэтгэл ханамжийн судалгаа (2014-2019 он)
- Багш нарын талаарх оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаа (2014-2019 он)

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/туршлага**

1. Багш, оюутан хамтран мэдлэг бүтээх идэвхтэй арга технологийг нэвтрүүлэх орчин, урамшууллын тогтолцоо, материаллаг бааз бүрдсэн.
2. Суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээний арга, хэлбэр, хүрэх үр дүн агуулгын хамаарлыг тогтоож хичээл бүрийн хөтөлбөрт тодорхой тусгасан.
3. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нэг бүрийн өөрийн сургалтын технологид идэвхтэй сургалтын арга зүйг нэвтрүүлсэн

**Анхаарах асуудал**

- Сургалтад мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи нэвтрүүлэх

**Зөвлөмж**

- Бусад их дээд сургуулиудын тэргүүний заах арга зүйч багш нарын үйл ажиллагааг судлан нэвтрүүлэх
- Асуудал шийдвэрлэх арга зүйг суралцагчдад түлхүү эзэмшүүлэхэд анхаарч ажиллах
- Мэргэжлийн байгууллагаас цагийн багш урин онол практик хослосон амьд сургалтыг явуулж байх
- Мэргэжлийн хуульчид болон бусад салбарын шилдэг эрдэмтэн мэргэжилтнүүдийг урин авчирч “Хуульчийн цаг”, “Мэргэжилтний цаг”, “Эрдэмтний цаг” гэх мэт танин мэдэхүйн уулзалт, ярилцлагыг тогтмол явуулдаг болох

## 2.3 Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд сургалтанд багц цагийн системийг нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлсэн (2015-2017 он )
- Отгонтэнгэр их сургуулийн удирдлагын мэдээллийн системийн шинэчлэл хийгдэж дүнг 9 баллаар үнэлдэг болсон.
- Шинэчлэгдсэн удирдлагын мэдээллийн систем (2019-2020 оны хичээлийн жилийн хоёрдугаар улирлаас хэрэгжинэ.)
- Отгонтэнгэр их сургуулийн бакалаврын сургалтыг зохион байгуулах журамд үнэлгээний талаар тусган зохицуулсан (2019 оны 04 дүгээр сарын 11-ны өдөр батлагдсан)

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/туршлага**

1. Суралцагчийн мэдлэг чадварыг үнэлэх үнэлгээний арга, хэлбэр, хүрэх үр дүн агуулгын хамаарлыг тогтоож хичээл бүрийн хөтөлбөрт тусгасан.
2. 2019 онд батлагдсан журмын дагуу суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх үнэлгээг шинэчилж 9 балын үнэлгээнд шилжиж, энэ хичээлийн жилээс эхэлж мөрдөж байна.

**Анхаарах асуудал:**

- Үнэлгээний шалгуурыг улам нарийвчлан шинэчлэх, үнэлгээний шинэ арга зүйч багш нар эзэмших /рубрик, танин мэдэхүй үе шатаар тест боловсруулах гм/
- Суралцагчид өөрөө өөрсдийгөө үнэлэх боломжийг судлан нэвтрүүлэх

- Суралцагчдын бие даалтын ажлыг үнэлэх шалгуурыг мэдлэг чадварынх нь түвшинг харгалзан гаргах

**Зөвлөмж:**

- Суралцагчдыг үнэлэх олон аргыг түлхүү хэргэлэх \аман шалгалт, эссе бичлэг, реферат, семинарын хичээл, харилцан ярилцлага, өөрөө өөрсдийгөө үнэлж дүгнэх, хичээл зааж байх

**2-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

*Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.*

**3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- ОТИС нь 1992 онд хичээлийн А байр, 1998 онд хичээлийн Б байр, 2005 онд хичээлийн В байрыг тус тус ашиглалтад оруулсан ба нийт 6.629 м<sup>2</sup> талбайтай бөгөөд *Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10<sup>1</sup>, 42 дугаар зүйлд заасан боловсролын байгууллагын сургалтын орчны тухай хэм хэмжээнд* нийцсэн, багш, суралцагчдын аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллаж, суралцах нөхцөл бүрдсэн, сургалтын үйл ажиллагаа, сурах, сургах үйл явцыг дэмжих сургалтын орчинг бүрдүүлэн ажиллаж байна.
- Хичээлийн байрны хувьд 1 ээлждээ 1.800 оюутны хүчин чадалтай. Суралцаж буй оюутны тоо нь сургуулийн хүчин чадалд тохирсон, ээлжийн ашиглалтын коэффициент 1,05 байгаа нь 1,5-аас ихгүй байх тухай заалтыг бүрэн хангасан байна. Нэг оюутанд оногдох талбай 3,5 м<sup>2</sup> болно. Сургуулийн барилга байгууламж, материаллаг нөхцөлийн үзүүлэлт, хүчин чадлыг тооцоолбол 2 ээлжээр бүрэн ажиллах сургалтын материаллаг нөөц бололцоо хангалттай байна. Эрх зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын үйл ажиллагаа нь ОТИС-ийн хичээлийн А байранд төвлөрөн Б болон В байруудад байрлах анги, танхимд явагдаж байна.
- Хичээлийн байрны давхар бүрт галын аюулгүй байдлын схемтэй, галын шаланг ба галын хор, аваарын гарцын тэмдэглэгээ бүхий бүрэн чөлөөлөгдсөн гарцуудтай, гамшгийн үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй, цахилгааны газардуулгын ажил хийгдсэн.
- Сүүлийн 5 жилд сургалтын орчны хүрээнд нийгмийн судалгааны төв, бие даалтын танхим, сайн дурын үйл ажиллагааны төв, Багшийн хөгжлийн төв, Green office төв, Карьер хөгжлийн төв зэргийг байгуулан тохижуулсан ба хичээл ордог бүх анги, танхим, төвүүдэд проектор, дэлгэц байрлуулсан байсан.
- Сүүлийн 5 жилийн байдлаар сургалтын техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, шинэчлэхэд зориулан 129.713.000 төгрөг, анги, танхимын урсгал засварт 206.774.970 төгрөг, тохижилтод 25.644.100 төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх “ЭШСТөв” нь өндөр хүчин чадал бүхий судалгааны программууд суулгасан, нэгдсэн хяналтын камерын сүлжээнд холбогдсон 20 компьютертой, 24МВ интернэтийн хурдаг, нээлттэй эх сурвалжуудыг ашиглах бүрэн боломжтой.

<sup>1</sup> Боловсролын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.10 “сургалтын орчин” гэж боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцааг;

- Багш, ажилтан, оюутны бие бялдрыг хөгжүүлэх, эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2016 онд 68.334.980 төгрөгийн санхүүжилтээр бялдаржуулах төв байгуулжээ. Тогтмол үйлчилгээ үзүүлж ажилладаг нь уулзалт асуулгаар тодруулсан.
- ОТИС нь 2 цайны газраар үйлчилж байгаа бөгөөд цайны газрын үйлчилгээний талаар тэднээс сэтгэл ханамжийн судалгааг тогтмол авч дүн шинжилгээ хийж үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулан ажилладаг тогтолцоо бүрдсэн.
- Багш, суралцагчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийх болон яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, өдрийн эмчилгээ хийх чиг үүрэг бүхий сургуулийн эмчтэй.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хууль зүйн клиник сургалтын төв, бие даалтын танхим, кабинетуудад мини номын сантай, оюутнууд бие даан хичээлээ давтахад шаардлагатай үндсэн сурах бичиг, хуулиудыг байршуулсан
- Өндөр хүчин чадал бүхий судалгааны программууд суулгасан, нэгдсэн хяналтын камерын сүлжээнд холбогдсон 20 компьютертой, 24МВ интернэцийн хурдайт, нээлттэй эх сурвалж, судалгааны программ ашиглах бүрэн боломжтой Эрдэм шинжилгээ, судалгааны төвтэй
- Эрх зүй хөтөлбөрийн суралцагчдын мэргэжлийн дадлага 1, 2 /танилцах болон үйлдвэрлэлийн/ хийх дадлагын бааз, оюутныг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ур чадварт сургах стандартын шаардлага хангасан ХЗКСТ ажиллаж байна.
- Хичээл ордог бүх анги, танхим, төвүүдэд проектор, дэлгэц байрлуулсан.
- Хичээлийн 3 байр давхар бүртээ ариун цэврийн өрөөтэй, дулаан, цэвэр, бохир усны системд бүрэн холбогдсон, жил бүр ундны усны шинжилгээ өгч хэвшсэн, багш, оюутанд зориулсан ундны цэвэр усны аппаратыг давхар бүрд байрлуулсан,
- Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд хог хаягдлыг ангилан хаях хогны сав давхар бүрд байрлах ба хог хаягдлыг ангилан хаях цэгтэй, байгууллагын хэмжээнд ариутгал, халдваргүйтгэлийн ажиллагааг тогтмол хийдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Хөндлөнгийн хяналт тавьдаг нэгжийн үйл ажиллагааг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөгөө, хяналт хийсэн тайлан, судалгаа, мэдээ мэдээллийг ил тод байдлыг төлөвшүүлэх
- Хууль эрх зүйн актуудын цахим сан заавал бий болгох \legalinfo сайтаас гадна сургалтад ашиглах боломжтой \
- Сургалтын орчинд аль болох боломжоороо нөхцөл байдалдаа тохируулан шинэчлэл байнга хийх \Хууль зүйн сургуулийн шинэ байр барьж ашиглалтанд орохыг хүлээж цаг алдахгүй байх\

#### **Зөвлөмж:**

- Анги танхимын дотоод үзэмжийг улам сайжруулах
- Сургалтын материалуудыг байнга шинэчилж байх
- Цайны газар, номын сан, оюутны клубууд, спорт заалыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа гол тоног төхөөрөмжүүд нь олшруулах машин, компьютер, LCD проектор, кодоскоп 1, ухаалаг самбар 1, зөөврийн хулдаасан самбар, зөөврийн цаасан самбар, хөлтэй самбар, постер самбар, скайнер, зүсэгч, ламинатор, зөөврийн компьютер зэрэг сургалтын орчин үеийн техник хэрэгслүүд болно.
- Багш нар хичээлдээ “Powerpoint”, ”Lingo”, “Flash Animation”, SPSS судалгааны программыг голлон ашиглаж байна.

- Эрх зүй хөтөлбөрийн суралцагчдын мэргэжлийн дадлага 1, 2 /танилцах болон үйлдвэрлэлийн/ хийх дадлагын бааз, оюутныг хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ур чадварт сургах стандартын шаардлага хангасан ХЗКСТ ажиллаж байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Эрх зүй хөтөлбөрийн багш, төгсөгчид, түншлэл, хамтын ажиллагаатай байгууллагуудын хандиваар оюутны бие даалтын төв /А-107/, Хууль зүйн клиник сургалтын төв /А111/, Оюуны өмчийн эрх зүйн кабинет /А204/, Эрдэм шинжилгээ-судалгааны төв /А110/ зэрэгт мэргэжлийн мини номын сан ажиллуулж, номын фондын баяжилт хийж, оюутан суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна.

**Анхаарах асуудал:**

- Хууль, эрхийн актуудыг CD- заавал буулгаж сургалтын хэрэглэгдэхүүн болгон ашиглах
- Шүүх хуралдаан, хавтаст хэргийн цахим бичлэгийг суралцагчдад хүртээмжтэй болгох үүднээс тоо ширхэгийг олшруулж, үр өгөөжийг нэмэгүүлэх, тэдгээрийн ашигласан байдалд дүн шинжилгээ хийх
- Сургалтын хэрэглэгдэхүүний төрөл, хэлбэрийг олшруулах, шинэчлэх
- Сургалтын кино, дүрс бичлэгийн тоог олшруулах \8 ш байгаа гэж тайланд тусгасан\

**Зөвлөмж:**

- Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад баримталж буй шалгууруудыг улам нарийвчлан гаргаж, ач холбогдлыг чухалчлах
- CD – д буулгасан сургалтын хэрэглэгдэхүүний хайрцаг савыг шинэчлэн үзэмжтэй болгох, товъёог гаргах
- Сургалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа гол гол техник тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх, нэр төрөл, тоо ширхэгийг нэмэгдүүлэх

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Номын сан нь 168 хүний суудалтай 2 уншлагын танхимтай, танхим бүр хяналтын камертай нийт 38.996 боть номын фонд бүхий 300м<sup>2</sup> талбай бүхий 2 номын сантай.
- Нэг оюутанд ноогдох мэргэжлийн ном, сурах бичиг 25-30ш, гадаад, дотоодын тогтмол хэвлэлийн тоо 35 байна.
- Номын сан 25 компьютертой, үүнээс интернэтэд 19 нь холбогдсон. Wi-Fi утасгүй интернэттэй.
- Номын сангийн LIB4U Net version программ хангамжтай, энэ нь интернэт сүлжээнд тулгуурлан үйлчилгээ явуулдаг бөгөөд нийт 8.982 төрлийн 37.076 ширхэг номын мэдээллийн санг цахим хэлбэрт оруулсан. 2016 оны байдлаар 9.162 төрлийн 37.303 ширхэг ном бүртгэгдсэн бол 2019 оны 6 сарын байдлаар 1.854 төрлийн 11.576 ширхэг ном бүртгэгджээ. Хөтөлбөртэй холбогдох 1.865 ном, сурах бичгийг E-ном хэлбэрт оруулж, багш, оюутанд үйлчлэх бэлтгэл хангаж байна.
- Zottero программ дээр “Монголын төр эрх зүй”, “Хууль дээдлэх ёс”, “Монгол Улсын дээд шүүхийн мэдээлэл” сэтгүүлүүдээр лавлагаа ном зүйн мэдээлэл болон 1.229 нийтлэлийг оруулжээ.
- Эрх зүй хөтөлбөрийн сургалтад ашиглаж буй сургалтын нээлттэй нөөц материалын сангийн хаяг, нээлттэй сурах бичиг санаачилгуудын жагсаалт, болон нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээлийн тэргүүлэх платформуудтай.
- Сургалтын техник тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалтын үйлчилгээ, дотоод болон гадаад сүлжээ, ОТИС-ийн хэмжээнд ашиглаж буй программ хангамжийг хариуцсан мэдээллийн технологи, сүлжээний ажилтныг үндсэн орон тоон дээр ажиллуулдаг.

- Тайлангийн хугацаанд эрх зүй хөтөлбөрийн хичээлд хэрэглэх 10.610.900 төгрөгийн программ хангамжийг худалдан авч ашиглаж байна.
- Оюутанд үйлчлэх интернэт төв, оюутны бие даалтын кабинет, клиник төв, номын сангийн орчинд утастай болон утасгүй интернэт орчныг бүрдүүлж, “Мобинет” компаниас 24 мегабит/секунд интернэтийн урсгал худалдан авч хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байна. Мөн тус компаниас гадаад public хаягийн үйлчилгээг авч ашигладаг байна.
- Эрх зүй хөтөлбөрийн мэргэжлийн суурь, мэргэжлийн хичээл, хууль зүйн клиник дадлагын хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүнийг хичээл тус бүрийн онцлогт нийцсэн, тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх арга барил, ур чадварт нийцсэн, олон хувилбартай, агуулга хэлбэр нь сургалт, танин мэдэхүйн ач холбогдолтой байх гэсэн нийтлэг шалгуурын дагуу боловсруулан сургалтад ашиглаж байна.
- Суралцагчдад улирлын үечлэл бүрийн эхэнд оюутнуудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр сургалтын ажлыг зохион байгуулах удирдамж, заавар, зөвлөмжүүдийг танилцуулж, дагаж мөрдөж хэвшсэн.
- Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ашиглах ном, бүтээл, сурах бичиг, гарын авлага зэрэг сургалтын хэрэглэгдэхүүний фонд бүрдүүлэлт, баяжуулалтыг хийхдээ тухайн хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу мэргэжлийн тэнхим, мэргэжлийн багш, хөтөлбөрийн хороодын санал, судалгаанд үндэслэн улирал тутам хийдэг нь хөтөлбөрийн агуулга, арга зүй, төгсөгчдийн эзэмшвэл зохих мэдлэгт нийцсэн.

**Шалгуурыг хангасан байдал:** *Бүрэн хангасан*

**Онцлог зүйл/Туршлага:**

- Эрх зүй хөтөлбөртэй холбогдох 1.865 ном, сурах бичгийг E-ном хэлбэрт оруулж, багш, оюутанд үйлчлэх бэлтгэл хангагдсан.
- Эрх зүй хөтөлбөрт хамаарах гарын авлага, сурах бичиг, эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, сургалтын хөтөлбөр, зөвлөмж, арга зүй онол практикийн товхимол, бодлогын болон хууль тогтоомжийн судалгаа зэрэг 1.817 нэр төрлийн 11.128 боть, 82.783.114 төгрөгийн үнэлгээ бүхий номын фондтой.
- Хөтөлбөрөөр суралцагч 1 оюутанд 20-25 үндсэн сурах бичиг, гарын авлага ноогдож байгаа нь үндсэн сурах бичиг, гарын авлага хүрэлцээтэйг харуулж байна.
- Эрх зүй хөтөлбөрийн номын сангийн фондыг 2014-2019 онд 33.753.865 төгрөгийн 731 нэр төрлийн 1.682 ном, сурах бичиг, гарын авлагаар баяжуулж, 14.102 нэр төрлийн 121.630 ширхэг ном, сурах бичиг, гарын авлагаар давхардсан тоогоор 88.664 уншигчдад үйлчилжээ.
- Номын санд ХЗС-ийн багш нарын дангаар болон хамтаар боловсруулж нийтийн хүртээл болгосон үндсэн сурах бичиг 158, сургалтын гарын авлага 2.189 байгаа бөгөөд ашиглалт, номын сангийн эргэлт нь 47.803 байна.

**Анхаарах асуудал:**

- Номын санд өөртөө үйлчлэх орчныг бүрдүүлэх \зарим ном, товхимол, сонин сэтгүүл зэргийг хүртээмжтэй, гар дор ашиглах боломжтой байдлаар байршуулах\
- Номын сангийн уламжлалт каталогийг цахим каталогтой уялдуулаг шинэчилж байнга ашиглах боломжтой болгох
- Номын санд хамрагдсан суралцагчдын талаар дэлгэрэнгүй мэдээлэл, тайлан, цаашид хэрхэн үр бүтээлтэй харуулах талаар төлөвлөж ажиллах шаардлагатай

**Зөвлөмж:**

- Шинээр худалдан авах номын жагсаалт, худалдан авах хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэрийн талаарх мэдээллийг ил тод болгох
- Бусад их дээд сургуулиудын номын сангуудын тэргүүн туршлагыг судалж нэвтрүүлэх

**3-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ:** *Бүрэн хангасан*



#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

##### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- 2012-2013 оны хичээлийн жилээс удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэх ажил эхэлж, одоогийн байдлаар сургалтын үйл ажиллагаандаа OneMIS /Management Information system/ сургалтын мэдээллийн системийг хэрэгжүүлж байна. 2015-2016 оны хичээлийн жилд БСШУСЯ-аас хэрэгжүүлсэн “Дээд боловсролын байгууллагын хөгжлийг дэмжих” тэтгэлэгт хөтөлбөрийн дээд боловсролын сургалтын үйл ажиллагаанд тэргүүн туршлага нэвтрүүлэн, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр удирдлагын мэдээллийн системийг сайжруулан боловсронгуй болгох төсөл бичиж шалгаран 60 сая төгрөгийн санхүүжилттэй төслийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнгээ тайлагнасан. Уг төслийн үр дүнд мэдээллийн системээ сайжруулахад шаардлагатай бусад модулиудыг нэмж боловсруулан ажиллажээ.
- ОТИС-ийн Хөтөлбөрийн хороо нь Ерөнхий хороо, Мэргэжлийн дэд хороо, Ерөнхий суурь хичээлийн хөтөлбөрийн дэд хороо гэсэн бүтэцтэй ажилладаг байна. Эрх зүй хөтөлбөрийн мэргэжлийн дэд хороотой, 2019 оны 4 дугаар сарын 11 өдрийн УЗ-ийн хурлаар Хөтөлбөрийн хорооны журмыг шинэчлэн баталсан. Хөтөлбөрийн хорооны журмаар Хөтөлбөрийн хорооны зорилго, баримтлах зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт, чиг үүрэг, тавигдах шаардлага болон үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулдаг.
- Эрх зүй мэргэжлийн хөтөлбөрийн хорооны хувьд сургалтын үйл ажиллагааг чанаржуулах үүднээс тэнхимийн зохион байгуулалт (Хувийн эрхзүйн тэнхим, Нийтийн эрхзүйн тэнхим)-аар ажилладаг бөгөөд сургалтын хөтөлбөрт оруулах санал, хүсэлтээ тэнхимээр хэлэлцүүлсний дараа хөтөлбөрийн дэд хороонд уламжилдаг учраас бүх багш нарын оролцоог бүрэн хангаж чаддаг байна.
- Тухайн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг хичээлийн жилийн эхэнд тэнхимийн хурлаар хэлэлцүүлэн баталж цаашид ажлын гүйцэтгэлийг цаг тухайд нь дүгнэн хэлэлцдэг байна. Жил бүрийн 5-р сар, эсвэл 9-р сард тэнхимийн эрхлэгч үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөний биелэлтийн талаар тэнхимийн хамт олонд тайлагнан хэлэлцүүлж, ажлаа дүгнэдэг.
- Эрх зүйн бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин бүрдсэн.
- Улирал бүр багш, оюутнаас социологийн болон сэтгэл ханамжийн судалгаа авч үр дүнг тогтмол хэлэлцэж хэвшсэн. Судалгааны үр дүн, дүгнэлт дээр үндэслэж холбогдох асуудлыг хөгжүүлэх, сайжруулах тал дээр тэнхим, салбар сургуулиуд зөвлөлийн хурлаар хэлэлцдэг байна.
- ОТИС-ийн суралцагчдаас ирсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсролын тухай хууль, ОТИС-ийн дүрэм, ОТИС-ийн бакалаврын сургалтыг зохион байгуулах журам, ОТИС-ийн шилжилт хөдөлгөөний журам, Хэрэглэгчдээс ирүүлсэн өргөдөл, санал, хүсэлт, гомдлыг шийдвэрлэх журам зэрэг эрх зүйн актуудыг үндэслэн шийдвэрлэдэг байна.
- Багш нарын зүгээс ирүүлсэн санал гомдлыг салбар сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцэж шаардлагатай тохиолдолд комисс томилон асуудлыг хэлэлцэж шийдвэрлэдэг байна. Оюутны санал гомдол нь ангийн багш, тэнхимийн эрхлэгч, салбар сургуулийн захирал, захирлын зөвлөл гэсэн шатлалаар дамжих бөгөөд шаардлагатай тохиолдолд санал



гомдлыг шийдвэрлэх эрх бүхий асуудлыг тухайн нэгж хариуцсан багш, эсвэл тэнхимийн эрхлэгч тэр даруйд нь шийдвэрлэх эрхтэй байдаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ISO нэвтэрсэнтэй холбоотой хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, санал гомдол шийдвэрлэхдээ зураглал, үйл явцын дагуу хүлээн авч, дүгнэлт өгөн сайжруулах ажиллагаа хийдэг.
- Хууль зүйн сургуулийн сургалтын үйл ажиллагаанд ОТИС-ийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн тухайн жилийн ОТИС-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон 2016-2022 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөөг мөрдлөг болгон ажиллаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хууль зүйн бусад сургуулийн туршлага, дэвшилтэт аргыг судлах, нэвтрүүлэх

#### **Зөвлөмж:**

- OneMIS /Management Information system/ сургалтын мэдээллийн системийг удирдлагын мэдээллийн системийн түвшинд бүрэн ашиглах

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Отгонтэнгэр их сургуулийн гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг хариуцсан нэгж ажиллаж гадаадын улс орнууд болон дотоодын бусад их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулалтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан дэд захирлын орон тоог шинээр бий болгон ажиллаж байна. Өмнөх магадлан итгэмжлэлээс хойш болон сүүлийн 4 жилийн хугацаанд сургуулийн хамтын ажиллагааны хүрээ нэлээд өргөжиж ахиц дэвшил гарсан гэж дүгнэж байна.
- Тиймээс сүүлийн жилүүдэд хамтын ажиллагааны хүрээнд оюутан болон багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, хамтарсан сургалтын хөтөлбөр боловсруулах чиглэлээр тус сургуулиас явуулж байгаа ажиллагаа нэлээд өссөн. Одоогийн байдлаар энэхүү оюутан солилцооны хөтөлбөрт 100 гаруй оюутан хамрагдаад байна. Мөн хамтын ажиллагаатай сургуулиудын багш болон оюутнууд тус сургуульд зочилж танилцах нөхөрсөг уулзалт, сургалт зохион байгуулахын зэрэгцээ эрдэм шинжилгээ судалгааны ажил явуулах, илтгэл хэлэлцүүлэх, зочин багш хүндэтгэлийн лекц унших зэргээр хамтран ажилладаг байна.
- Сүүлийн жилүүдэд тус сургуулийн 20 орчим багш давхардсан тоогоор туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын зэрэг хамгаалах, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох зэрэг ажлаар ОХУ, БНХАУ, Япон, Тайвань, Швейцар, БНТУ, АНУ, Ирланд, ХБНГУ, Голланд зэрэг орны их дээд сургуулиуд болон мэргэжлийн байгууллагуудтай санал солилцож ажилласан байна.
- ОТИС нь төгсөгчдийнхөө ажил эрхлэлт, ахисан шатны сургалт болон төгсөлтийн дараах сургалт зэрэгт анхааран ажиллаж, мөшгөх судалгаагаар дамжуулан давтан сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог бөгөөд ОТИС-ийн Эрх зүй хөтөлбөрөөр төгссөн төгсөгчдийг ажлын байранд зуучлах, зөвлөн туслах үйлчилгээг Хууль зүйн клиник төвөөс санаачлан хэрэгжүүлж, сүүлийн 4 жилд нэлээд олон төгсөгчийг ажлын байранд зуучилсан байна.
- 1996 оноос ОТДС-ийн, 1999 оноос ХЗС-ийн төгсөгчдийн холбоо байгуулагдан ажиллаж үйл ажиллагаа нь тогтмолжсон ба 2018-2019 оны хичээлийн жилд төгсөгчдийн холбооны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн, ОТИС-ийн Төгсөгчдийн холбоо нэртэй болгон тэргүүнээр хууль зүйн сургуулийн 2012 оны төгсөгч Ү.Амарбатыг сонгож, 1995 оноос

хойшхи жил бүрийн төгсөлтийн нэг төлөөлөл нийт 22 хүний бүрэлдэхүүнтэй Удирдах зөвлөлийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХЗС-ийн багш ХБНГУ, (ӨМӨЗО), Оросын Холбооны Улс (ОХУ), Бүгд Найрамдах Турк Улс (БНТУ), Япон, АНУ, Австрали, БНСУ, БНХАУ, Швейцар, Малайз, Их Британи, Испани, Итали, Армени, Бразил, ОХУ-ын их дээд сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцан, туршлага судалж ирсэн.
- Гадаадад томилолтоор ажилласан багш нар харилцан туршлага солилцож, хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээний талаар сайжруулах арга хэмжээ авч ажилласан нь сургалтын хөтөлбөрийн чанарт ач холбогдолтой болж чадсан.
- Профессор, багш нар нь мэргэжлийн чиглэлээр мэргэжлийн холбоо, хороо, зөвлөл, нийгэмлэгийн тэргүүн, удирдах зөвлөлийн гишүүн, гишүүнээр ажилладаг нь хамт олон сургалт, эрдэм шинжилгээний хувьд хүлээн зөвшөөрөгдөж байгаагийн нэг нотолгоо юм. Тухайлбал, ХЗС-ийн багш Д.Наранчимэг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр ажиллаж, ХЗДХЯ, Германы олон улсын нийгэмлэгтэй хамтран ажиллаж Иргэний эрх зүйн хүрээнд төсөл, хөтөлбөр удирдсаар ирсэн. Багш Д.Эрдэнэчимэг Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбооны тэргүүнээр ажиллаж, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн сонгон шалгаруулалт, оюуны өмчийн эрх зүйн улсын хэмжээний шалгалтыг удирдан зохион байгуулсан. Багш Ц.Алтанцэцэг, Д.Эрдэнэчимэг, С.Эрдэнэболор нар Хуульчийн сонгон шалгаруулалтын шалгагч багшаар ажилласан, М.Сувд, Р.Очирбал, Л.Баасан нар худалдааны арбитраж арбитражаар ажилласан зэрэг олон хамтын ажиллагааг хэрэгжүүлсэн байна.
- Төгсөгчдийн холбооноос Ментор төслийг хэрэгжүүлж, 3 дугаар дамжаа болон төгсөх ангийн нийт 12 оюутныг цалинтай дадлагажуулж байна.

##### **Анхаарах асуудал:**

- Цаашид дээрх ажлуудаа улаи сайжруулж сургалтын ажилтай уялдуулах

##### **Зөвлөмж:**

- МХХ, Монголын өмгөөлөгчдийн холбоо болон мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэх ажлаа нэмэгдүүлэх

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- ОТИС-ийн санхүүгийн төлөвлөлтөд эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулагдах зардлыг жил бүр ОТИС-ийн санхүүжилтийн төсөвт суулган Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэдэг бөгөөд гүйцэтгэлд сургуулийн захирал хяналт тавин ажиллаж удирдах зөвлөлд тайлагнадаг байна.
- 2016 оноос нягтлан бодох бүртгэлийн Impact программ, цалингийн Payroll программ ашигладаг болсон нь цаг тухай бүрт гүйцэтгэлд хяналт тавих боломжтой, тайлан мэдээ гаргах, удирдлагыг санхүүгийн мэдээллээр хангах үйл ажиллагааг хялбаршуулсан зэрэг давуу талыг бий болгосон байна. Бүтцийн болон салбар сургуулиудын захирлууд хичээлийн жилийн төгсгөлд хамт олны хуралд үйл ажиллагааны тайлангаа тавьж, хэлэлцүүлдэг.
- Сургууль нь нэгдсэн төсөвтэй бөгөөд бүтцийн сургууль бие даан төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлэхгүй харин хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж нь төсөвт санал оруулах, үндэслэл, захиалга, шаардлага хэрэгцээний судалгаа гаргаж шаардлагатай техник хэрэгсэл, материаллаг зүйлсийг авч ашиглах, асуудлыг шийдвэрлэхэд оролцох, шаардлагатай төсвийг ОТИС-ийн захирлаар батлуулан зарцуулдаг журамтай.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр нь сургалтын төлбөр бөгөөд төлбөрийн хэмжээг тухайн үеийн инфляцын түшингээс хамаарч жил бүр шинэчлэн ОТИС-ийн Удирдах зөвлөлөөр хэлэлцэн баталдаг. Эрх зүй хөтөлбөрийн сургалтын төлбөр сүүлийн 3 жилд тогтмол байсан. Харин 2019-2020 оны хичээлийн жилээс Англи хэлний ЕАР хөтөлбөр хэрэгжих болсонтой холбоотойгоор Эрх зүй хөтөлбөрийн сургалтын төлбөр нэмэгдсэн.
- Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор багш нарт зориулан ОТИС-ийн төвлөрсөн төсвөөс төрөл бүрийн санхүүжилтийг олгодог байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эрх зүй хөтөлбөрөөр суралцагчийн төлбөрөөс 2015-2019 оны байдлаар нийт 340 орчим сая төгрөгийн хөнгөлөлтийг эдлүүлсэн байгаагаас харахад хөтөлбөрийн санхүүжилтийг суралцахууд чиглэсэн үйл ажиллагаанд зарцуулдаг болохыг харуулж байна.
- УЗ-ийн хурлаар докторын зэрэг хамгаалсан багшийг 3 сая, шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан багшийг 5 сая төгрөгөөр урамшуулах журмыг батлан хэрэгжүүлж эхлээд нийт 42 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

##### **Анхаарах асуудал:**

- Цаашид ажлаа улам сайжруулан төлөвшүүлэх

##### **Зөвлөмж:**

- Оюутны хүрээнд тэдний сурлагын амжилт, эрдэм шинжилгээний ажилд оролцсон байдал зэргийг харгалзан санхүүжилт, урамшууллын тогтолцоог зохих ёсоор хэрэгжүүлэх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- 2015-2016 оны хичээлийн жилд маркетингийн албаны шинэ бүтэцтэй болсноор сурталчилгааны арга хэлбэрийг өөрчлөн, хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт, шинэчлэх ажиллагаа эрчимжиж ахиц дэвшил гарчээ.
- Эрх зүйн хөтөлбөртэй холбогдуулан сургууль, сургалтын хөтөлбөрүүдтэй танилцуулах, сурталчлах арга хэмжээг хичээлийн жил бүр тасралтгүй явуулж байгаа бөгөөд 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн тус сургуулиас санаачлан зохион байгуулсан мэтгэлцээнийг улсын хэмжээнд зохион байгуулах, сургууль мэргэжлээ сурталчлах ажлыг улс, аймаг, сумын хэмжээний ЕБС-ийн сурагч, багш нарын хүрээнд хэрэгжүүлсэн нь шинэлэг бөгөөд үр дүнтэй олон нийтэд мэдээлэх цар хүрээг өргөжүүлсэн ажил болсон байна.
- МИДСК, ХИДСХ-оос зохион байгуулсан боловсролын үзэсгэлэн яармагт тогтмол оролцох, телевизийн суваг, Зууны мэдээ, Өдрийн сонин, Үнэн, Үндэсний шуудан зэрэг өдөр тутмын хэвлэлд сургуулийн танилцуулгаа нийтлүүлдэг байна
- Отгонтэнгэр их сургуулийн эрхэм зорилго, зорилтуудаа жил бүрийн хавар зохиогддог “Нээлттэй хаалганы өдөр”-өөр сонирхогчид, элсэгчид, эцэг эхчүүдэд таниулан сурталчлах үйл ажиллагааг явуулж хэвшсэн.
- Отгонтэнгэр их сургуулийн хэмжээнд мөрдөгдөх дүрэм журмын эмхэтгэл ном 2012 онд хэвлэгдсэн ба түүнээс хойших хугацаанд дотоодод мөрдөгдөх эрх зүйн актуудад зарим нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр батлах зэргээр эрх зүйн бодлогын баримт бичгийн шинэчлэл хийгдэж энэ талаарх мэдээллийг сургуулийн хамт олонд танилцуулах, мөрдлөг болгон хэрэгжүүлэх, түүний хэрэгжилтийг хангах зорилгоор сургуулийн цахим хуудаст холбогдох дүрэм журмыг байршуулжээ. Иймд сургуулийн сургалтын талаарх дүрэм журмуудыг багш, оюутнууд Отгонтэнгэр их сургуулийн цахим хуудаснаас үзэж танилцах бүрэн боломжтой

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2014-2015 оны хичээлийн жилд ОТИС-ийн брэнд бук (brand book)-ийг хэвлэн гаргажээ. Энэхүү брэнд бук-д өнгө, лого, хэвлэлт, бичиг хэрэг, мэдээлэл, сурталчилгаа, вэб хуудасны ерөнхий дизайн зэргийг нарийн зааж өгсөн нь ОТИС-ийг илэрхийлэх соёлын нэг хэсэг болжээ.
- Космо студент /Cosmo Student/ сэтгүүл гаргах ажлыг Ирмүүн агентлагтай хамтран зохион байгуулж нийт 4 дугаарыг уншигчдын хүртээл болгосон байна.
- Сургуулийн эрхэм зорилгодоо хүрч ажиллах үүднээс багш, оюутнуудыг олон улсын болон үндэсний хэмжээний томоохон уралдаан тэмцээнүүдэд тогтмол оролцуулах явдлыг бодлогоор хөхиүлэн дэмждэг байна. Тухайлбал 2015 онд Хууль зүйн сургуулийн багш Ү.Амарбат, оюутан Энх-Үйлс нар 180 улс оролцсон Мэтгэлцээний дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсаа төлөөлж Отгонтэнгэр их сургуулийн нэрийн өмнөөс амжилттай оролцжээ.
- МХХ-оос зохион явуулдаг улсын аварга шалгаруулах “Шүүхийн мэтгэлцээн”-ий тэмцээнд Хууль зүйн сургуулийн багш, оюутны баг хамт олон жил дараалан тэргүүн болон дэд байранд шалгарсан бол Үндэсний болон нийслэл, дүүргийн аварга шалгаруулах ”Парламентын мэтгэлцээн”-ий тэмцээнд мөн тэргүүн, дэд байруудад тус сургуулийн оюутнууд тогтмол байр эзэлсэн амжилт гаргасан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Багш оюутнуудыг аль болох бүрэн хамруулах \Идэвхтэй цөөн хүмүүсийн хүрээнд биш \

#### **Зөвлөмж:**

- Дурдсан ажлуудыг чанаржуулж, байнгын болгож төлөвшүүлэх ,
- Туршлага арга барилаа сурталчлах, бусад сургуульд түгээх, туршлага солилцож байх

### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Онлайн элсэлт болон сургалтын үйл ажиллагаандаа дараах албан ёсны веб хаягуудыг ашигладаг байна. Үүнд:
  - албан ёсны веб хаяг <http://www.otgontenger.edu.mn>
  - диплом шалгах программ <http://checkdiploma.otgontenger.edu.mn>
  - элсэлтийн онлайн программ <http://otgontenger.gate.mn>
  - багшийн веб: <http://teacher.otgontenger.edu.mn>
  - оюутны веб: <http://student.otgontenger.edu.mn>
  - [www.otgontenger.edu.mn](http://www.otgontenger.edu.mn) домэйн нэр дээр байрлах бөгөөд хостинг нь ns.1gb\_mn.com 74.220.195.44 серверт байрлуулан Datacom компанитай албан ёсоор хамтран ажилладаг байна. Тухайн хөтөлбөрийн танилцуулга, суралцагчийн эзэмших ур чадвар, элсэгчид тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд, суралцах ачаалал, багц цагийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэн [www.otgontenger.edu.mn](http://www.otgontenger.edu.mn) албан ёсны сайтаар мэдээлэл түгээдэг.
- Эрх зүй хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оюутнуудад зориулж Хөтөлбөрийн гарын авлага, Оюутны гарын авлага, Дүрэм журмын эмхэтгэл хэрэглэгддэг. Хөтөлбөрийн гарын авлагад эрх зүй хөтөлбөрийн хичээлүүдийн хөтөлбөрийн мэдээлэл байдаг бол оюутны гарын авлага нь оюутныг сурахад чиглүүлэх мэдээлэл агуулдаг байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын үйл ажиллагааг зохицуулах удирдлагын тогтолцоо төлөвшсөн.

- Багш нарын мэдлэг, чадвар, туршлагад суурилсан дотоод, гадаадын олон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.
- Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаагаар дамжуулан эрх зүй хөтөлбөрийг идэвхжүүлэх ажил идэвхтэй хийгддэг.
- Чанарын баталгаажилтын ISO-9001:2015-г нэвтрүүлсэн
- Багш, оюутан, тэнхим нэгж, алба, захиргааны талаарх мэдээлэл түгээх цахим орчин бүрдсэн

#### **Анхаарах асуудал:**

- Шинэ арга барил нэмж хэрэгжүүлэхэд анхаарч суралцагчид болон олон нийтэд мэдээллээ хүргэх

#### **Зөвлөмж:**

- Ажлын арга барил, үйл ажиллагаагаа улам боловсронгуй болгоход байнга анхаарч тухайн асуудлыг хариуцсан ажилтантай байх,
- Нээлттэй, ил тод байдлыг хангах ажлын үр дүнг жил бүр тооцон дүгнэх ажлыг тогтмолжуулах

#### **4-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

*Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.*

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын нэгдсэн албаны тайлан /2014-2019/-уудад элсэгчдийн тоо мэдээ, түүнд хийсэн анализ байна.
- Бакалаврын сургалтын зохион байгуулахад баримтлах журам /107 тал 7-р хэсэг/
- 2019-2020 оны хичээлийн жилийн элсэлтийн комисс томилох, журам батлах тухай А/64 захирлын тушаал
- 2017-2018 оны хичээлийн жилийн элсэлтийн комисс томилох, журам батлах тухай А/50 захирлын тушаал
- Шинээр элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага 2017 он
- Шинээр элсэгчдэд зориулсан оюутны гарын авлага 2019 он
- ОТИС-ийн сургалтын нэгдсэн алба нь тэнхим нэгжийн багш нараас оролцуулан элсэлтийн арга хэмжээг зохион байгуулдаг ба элсэгч болон суралцагчдын бүртгэл судалгааг хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж ажилладаг байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ОТИС-ийн сургалтын алба нь тэнхим нэгжийн багш нараас оролцуулан элсэлтийн арга хэмжээг зохион байгуулдаг ба элсэгч болон суралцагчдын бүртгэл судалгааг хийж, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж байна.
- Маркетингийн алба, сургалтын алба хамтран мэдээллийн нэгдсэн сан дээр тулгуурлан анализ хийж ажилладаг байна. Тухайлбал бүртгүүлсэн болон элсэн орсон оюутны тоо мэдээ, шинээр элсэж орсон оюутнуудын хөнгөлөлт авсан оюутнуудын анги дэвшилт зэрэгт анализ хийжээ.
- Элсэгчдэд зориулсан маркетингийн албанаас боловсруулсан онцлог ажил Баян-Өлгий аймгийн элсэгчдэд зориулж элсэгчдэд зориулсан материалаа казак хэлээр хөрвүүлж, казак

хэлтэй багшийг элсэлтийн комисст оруулснаар Баян-Өлгий аймгаас элссэн оюутны тоо 3 дахин өссөн сайн туршлага байна.

- Шинээр элсэгчдийн хөнгөлөлт, урамшууллын бодлого явуулж элсэгчдийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.
- ОТИС-д оюутан элсүүлэх талаарх дүрэм журам болоод элсэгчдэд зориулсан сурталчилгаа, мэдээллийг цахим орчноор болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүргэдэг байна.
- Шинэ элсэгчдэд зориулсан оюутны гарын авлагыг хэвлэж, түгээхийн хамт номын сан, клиник сургалтын төв, оюутны бие даалтын танхимдаа байршуулж оюутнууд ашигладаг. Хөтөлбөрийн өөрчлөн сайжруулалттай холбогдуулан гарын авлагыг мөн адил засан сайжруулж хамтдаа гаргадаг.

#### **Анхаарах асуудал:**

- Хууль зүйн бусад сургуулийн туршлага судлах

#### **Зөвлөмж:**

- Гадаад улс орны оюутан элсүүлэх бодлогыг судалж, төлөвлөлт хийх

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тэнхим, сургуулийн эрдэм, шинжилгээ судалгааны тэргүүлэх чиглэл батлагдсан байдаг ба үүнтэй уялдуулан багш, оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж хэвшсэн байна.
- Оюутан багш нар хамтарсан төсөл хөтөлбөрт оролцдог
- Эрдэм шинжилгээ судалгааны төв дээр тухайн жилд амжилт үзүүлсэн оюутан болон багш нарын бүтээлийг эмхэтгэж нийтийн хүртээл болгодог
- Оюутны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол явуулж, холбогдох нэгжид гарсан үр дүнг танилцуулахын хамт үйл ажиллагаандаа хэрэгжүүлж сайжруулалт хийх үүрэг даалгаврыг Дотоод хяналт шинжилгээний албанаас үүрэг даалгавар өгч, холбогдох нэгжүүд төлөвлөлт дээрээ тусган ажилладаг байна.
- Оюутнуудад мэтгэлцэх ур чадвар олгох зорилготой Оюуны тулах цэг клуб, Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилготой Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Ажлын байранд шаардагдах ур чадварыг олгох Career Development Center of Olgontenger University, оюутнуудад зөв хандлага төлөвшүүлэх зорилготой Green office ажилладаг байна..
- Оюутны холбоо нь зохион байгуулсан үйл ажиллагаа, түүний санхүүжилт зарцуулалтын талаар тухай бүрт Оюутан- Радио болон оюутны холбооны самбарын мэдээлэл, ангийн дарга нарын уулзалтаар танилцуулдаг байна. 2014-2019 оны хичээлийн жилд оюутнуудын дунд 43 ажил зохион байгуулахад нийт 17.464.180 төгрөгийг сургуулийн санхүүжилт авч, зарцуулсан байна.
- Ерөнхий боловсролын сургуулиудын дунд үндэсний хэмжээний мэтгэлцээн зохион байгуулсан. Дэлхийн мэтгэлцээний аварга шалгаруулах тэмцээнд оюутан, багш нарын төлөөллийг оролцуулдаг.
- Улсын аварга шалгаруулах шүүхийн мэтгэлцээний тэмцээнд удаа дараа амжилттай оролцож байсан байна.
- Мэргэжлийн чиглэлийн 4, Хувь хүний хөгжлийн чиглэлээр 8 дугуйлан клубт ХЗС-ийн оюутнууд хамрагддаг байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**



- Оюутныг чадваржуулах зорилготой олон төрлийн дугуйлан клуб, төвүүд ажилладаг. Тухайлбал: Хууль зүйн клиник сургалтын төв, Тулах цэг клуб, Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, Ажлын байранд шаардагдах ур чадварыг олгох төв, оюутнуудад зөв хандлага төлөвшүүлэх зорилготой Грийн офисс ажилладаг байна..

**Анхаарах асуудал:**

- Төлбөрийн чадваргүй иргэдэд хүрч үйлчилгээ үзүүлэх асуудлыг судлах
- Тэдэнд үйлчлэх үйлчилгээг өргөжүүлэх

**Зөвлөмж:**

- Засгийн газраас хэрэжүүлж байгаа бүх нийтийн эрх зүйн боловсролын ажилд идэвхтэй оролцох

**5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Боловсролын зээлийн сангаас олгодог буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлээс гадна, 2014-2019 оны хичээлийн жилд нийт 271 оюутанд 340.140.000 төгрөгийн тэтгэлэг олгосон байна.
- А үнэлгээтэй суралцсан оюутнуудын эцэг, эх болон ажлын газраар нь дамжуулан ОТИС-ийн үүсгэн байгуулагчийн “Талархлын захидал” гардуулдаг уламжлалт ажил нь жилээс жилд өргөжин тэлж оюутан, эцэг эхийн талархлыг хүлээсэн, сургуулийг олон нийтэд сурталчлан таниулах ажлын үр дүнг дээшлүүлсэн томоохон ажлын нэг болдог байна.
- ОТИС-ийн Захирлаар ажиллаж байгаа Н.Энхзаяагийн нэрэмжит тэтгэлгийг жил бүр олгодог.
- Ректорын зөвлөлийн 2012 оны 01 тоот хурлаар баталсан “Багш, ажилтнуудад тэтгэмж, тусламж үзүүлэх журам”-ын дагуу тус сургуульд ажиллаж байгаа багш, ажилчин, ажилтны нэг хүүхдийг тус сургуульд суралцах сургалтын төлбөрийг сургууль даана. Хоёр хүүхэд суралцдаг бол хоёр дахь хүүхдийн сургалтын төлбөрийг 50 хувийг сургууль даадаг байна.
- Мөн бага насны хүүхэдтэй оюутан суралцагчдын хүүхдийг сургуулийн түшиц “Одтой жаалууд” цэцэрлэгт тодорхой хөнгөлөлтэйгөөр суралцах боломжийг олгодог байна.
- Оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, уулзалтыг зохион байгуулахаас гадна сургуулийн Фитнес төвөөр үйлчлүүлэх боломжтой байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- “Багш, ажилтнуудад тэтгэмж, тусламж үзүүлэх журам”-ын дагуу тус сургуульд ажиллаж байгаа багш, ажилчин, ажилтны нэг хүүхдийг тус сургуульд суралцах сургалтын төлбөрийг сургууль даана. Хоёр хүүхэд суралцдаг бол хоёр дахь хүүхдийн сургалтын төлбөрийг 50 хувийг сургууль даадаг.
- Мөн бага насны хүүхэдтэй оюутан суралцагчдын хүүхдийг сургуулийн түшиц “Одтой жаалууд” цэцэрлэгт тодорхой хөнгөлөлтэйгөөр суралцах боломжийг олгодог нь орон нутгаас ирж суралцаж байгаа эчнээ ангийн оюутнуудад маш давуу тал болдог байна.
- Оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, уулзалтыг зохион байгуулахаас гадна сургуулийн Фитнес төвөөр үйлчлүүлэх боломжтой нь тэдний эрүүл мэндийг дэмжсэн бодит ажлын нэг юм байна.

**Анхаарах асуудал:**

- Сурацагч бүрийн нарийлчилсан судалгаанд үндэслэн урамшуулалд хамруулах оюутнуудыг тодорхойлж байх

**Зөвлөмж:**

- Суралцагчдын олон нийтийн оролцоо урамшууллын талаар туршлага болохуйц тогтолцоо бий болгон төлөвшүүлэх

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Отгонтэнгэр их сургуулийн бакалаврын сургалтыг зохион байгуулахад баримтлах журмын дагуу оюутны шилжилт хөдөлгөөнийг зохицуулдаг.
- Шилжилт хөдөлгөөний үед ОТИС-ын захиргаанаас ашигладаг Маягт/загвар/ бөглүүлэн шалтгаан нөхцөлийг судлан дүгнэлт хийн ажилладаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Жил бүрийн суралцагчдын шилжилт хөдөлгөөнд сургалтын алба, дотоод хяналт шалгалтын үнэлгээний албанаас анализ хийж үр дүнг тооцож ажилладаг

**Анхаарах асуудал:**

- Жил бүрийн шилжилт хөдөлгөөний судалгаанаас харахад сургуулиас гарсан үзүүлэлт бусад шилжилт хөдөлгөөнөөс өндөр байна.

**Зөвлөмж:**

- Сургуулиас гарч байгаа шалтгааныг судалж, анализ хийн үйл ажиллагаандаа ашиглаж байх

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Эрх зүй бакалаврын хөтөлбөрөөр суралцан төгсөгчид олгодог диплом нь Монгол, Англи хэлээр бичигдэхээс гадна Монгол бичгээр бичигддэг онцлогтой. Монгол бичгээр мэдээлэл мөн ордог.
- Сургуулийн архивд төгсөлтийн салбар комиссын хурлын шийдвэр, диплом олгосон бүртгэлийн хуулбар, хамгаалуулах зөвлөлийн хуралдааны протокол, тогтоол, удирдагчийн тодорхойлолт, суралцсан хугацааны тодорхойлолт, дипломын хуулбар, хуудас зэрэг баримт бичгүүдийг оюутан тус бүрээр бүрдүүлж хадгалдаг.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Тогтоосон дүрэм журамд бүрэн нийцүүлсэн, баримт бичигт тусгавал зохих үзүүлэлтүүд бүрэн тусгагдсан, уг ажиллагаа бүрэн төлөвшсөн

**Анхаарах асуудал:**

- Төгсөлтийн баримт бичгийн болосруулалт, өнгө үэмжийг улам сайн болгоход анхаарах

**Зөвлөмж:**

- Төгсөлтийн баримт бичгийн бүрдүүлбэр, сургуулиас олгосон баримт бичгийг төгсөгч бүрт цахим хэлбэрээр хэрэгтэй үедээ ашиглах боломжийг судлах.

**5-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**



**Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.**

### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилгоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Эрх зүйн хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын бүрэлдэхүүнд Зөвлөх профессор – 3, үндсэн багш – 16, үүний 75 хувь нь МХХ-ны гишүүн, Хуульч профессор багш байна. Мэргэжлийн гишүүнчлэлээр ажилладаг болон үндэсний хэмжээний сургагч багшийн эрхтэй багш нарын эзлэх хувь хангалттай байгаа боловч 26 хувь нь эрдмийн зэрэгтэй багш нар ажиллаж байна.
- ОТИС-ийн Багш сонгон шалгаруулж авах журмын дагуу багшийн нөөцөө нээлттэйгээр бүрдүүлдэг тогтолцоотой.
- Багшийн цагийн ачааллыг тогтоохдоо Монгол Улсын их дээд сургуульд баримталж буй нийтлэг жишигтэй дүйцсэн, мөн ОТИС-ийн Профессор, багш нарын гүйцэтгэх ажлын хэмжээ, багц цагийн норм тогтоох журмын дагуу багш нарын тухайн жилд гүйцэтгэх ажлын ачааллыг тооцдог байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ОТИС нь Багш, ажилтанд урамшуулал, хөнгөлөлт, тэтгэмж, тусламж үзүүлэх журамтай.
- Сүүлийн 5 жил ХЗС-ийн 4 багшийн 5 хүүхэд “Оюутны сургалтын төлбөрийн 100% -ийн хөнгөлөлт”, 3 багш Магистр, докторын сургалтын төлбөрийн 50-100%-ийн хөнгөлөлт, 3 багшийн 4 хүүхэд “Цэцэрлэгийн төлбөрийн 50% -ийн хөнгөлөлт” тус тус эдэлжээ.
- Эрдмийн зэрэг хамгаалсан ХЗС-ийн 2 багшид тус бүр 3.000.000 төгрөгийн урамшуулал, дэд профессорын цолтой багшид цалингийн 15%-ийн нэмэгдэл олгодог урамшууллын хөшүүрэгтэй.
- Багшийн нөөцийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зарлан сонгон шалгаруулдаг тогтолцоотой
- Багш нар тогтвор суурьшилтай ажилладаг
- Багшлах боловсон хүчний залгамж холбоотой, дунд үеийг бэлтгэн, залуу үеийг дагалдуулан сургах тогтолцоог баримталдаг
- Багш, ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдэх асуудлыг анхаардаг.

#### **Анхаарах асуудал:**

- Докторын зэрэгтэй багш нарын тоог нэмэгдүүлэх, нөхцөлийг бүрдүүлэх
- Багш, ажилтнуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдэх асуудлыг бодитой ил тод, нээлттэй болгох

#### **Зөвлөмж:**

- Эрдэмтэн багш нарын санал хүсэлтийг анхааран үзэж түүнд тулгуурлаж байх

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- 2018-2019 оны хичээлийн жилд Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ОТИС-ийн багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж зохион байгуулах, багшийн өөрийн хөгжлийн үйл явцыг дэмжих чиг үүрэг бүхий үйлчилгээний нэгж статустай “Багшийн хөгжлийн төв”-ийг байгуулсан байна. Тус төв ухаалаг самбар бүхий орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд дотоод болон гадаадын боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, заах арга зүйн асуудлаар дагнан

нийтийн хүртээл болдог эрдэм шинжилгээний сэтгүүл, гарын авлага бүхий бичил номын сантай.

- 2018 онд ОТИС нь 2018-2022 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх “Багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” боловсруулан мөрдөж байна. Уг хөтөлбөр нь Отгонтэнгэр их сургуулийг хөгжүүлэх бодлогын хэрэгжилт, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан ОТИС-ийн багш нарыг үе шаттайгаар хөгжих таатай нөхцөл бүрдүүлж, багшийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, харилцаа хандлага, ёс зүй, багшийн үнэлэмжийг нэмэгдүүлэх, судалгаа шинжилгээний арга зүйд сургах, эрдмийн зэрэг цолтой, шилдэг багш нарын тэргүүн туршлагыг түгээх, нэр хүндийг нь өсгөх зорилготой байна.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Бие даасан багшийн хөгжлийн хөтөлбөртэй, хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн хөгжлийн төвтэй
- Багш нараа 2018 оноос вакумжуулсан англи хэлний сургалтанд хамруулж эхэлсэн ба залуу багш нараа OXFORD-ын сургалтанд хамруулж, туршилтаар англи хэл дээр хичээл заалгах ажлыг хэрэгжүүлж эхэлсэн.

**Анхаарах асуудал:**

- Багш бүр өөрийн хөгжлийн төлөвлөгөөний үндэслэл, бодитой байхад анхаарч байх

**Зөвлөмж:**

- Өөрийн хөгжлийн төлөвлөгөө, түүний бүтэц арга зүйн талаар аргачилал боловсруулан түүндээ тулгуурлаж байх

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗС-ийн багш нар дараах эрдэм, шинжилгээ, судалгааны ажлыг хийж гүйцэтгэжээ. Үүнд:
  - Илтгэл –141
  - Боловсруулсан сурах бичиг - 34
  - Нийтлүүлсэн өгүүлэл - 95
- ХЗС-ийн багш нар сүүлийн 5 жилийн хугацаанд төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран нийт 41 төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.
- ХЗС-ийн багш нар сүүлийн 5 жилд 152 байгууллагын дангаар болон хамтран зохион байгуулсан сургалт, семинарт давхардсан тоогоор 332 удаа мэргэжил, ур чадвараа дээшлүүлсэн байна.
- ОТИС-ийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, эрдэм шинжилгээ, багшийг хөгжүүлэх хөтөлбөрүүд, бодлогын зорилго, зорилт, ОТИС-ийн дүрэм, бүтцийн шинэчилсэн өөрчлөлт, боловсролын салбарын төрийн бодлого, эрх зүйн шинэчлэлтэй уялдуулан тус сургуулийн сургалт, эрдэм шинжилгээ, багш, ажилтан, суралцагчийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг шинэчлэх зорилт тавигджээ. 2018-2019 оны хичээлийн жилд “ОТИС-д мөрдөгдөж буй эрх зүйн актуудад хяналт шинжилгээ хийж, Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийн баг, хамт олон байгуулагдан ажиллаж сургуулийн 3 дахь удаагийн шинэчлэн найруулсан эрх зүйн актуудыг системчлэн ОТИС-д мөрдөгдөж буй эрх зүйн актуудад хяналт шинжилгээ хийж Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн батлуулжээ.

**Шалгуурыг хангасан байдал:** Бүрэн хангасан

**Онцлог зүйл/Туршлага:**

- Сүүлийн 5 жилийн хугацаанд ХЗС-ийн 2 багш Хууль зүйн доктор /Ph.D/-ын зэрэг хамгаалсан байна.
- Боловсрол судлалын салбар эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж хэвшсэн байна.

**Анхаарах асуудал:**

- Сүүлийн 5 жилийн байдлаар хэлэлцүүлсэн илтгэл болон хэвлүүлсэн сурах бичиг гарын авлагын тоо сүүлийн жилд буурсан байгаад дүн шинжилгээ хийх
- Олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэхэд анхаарах

**Зөвлөмж:**

- Цаашид судалгааны ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, судалгааны сургууль болох зорилт хэрэгжүүлэх

**6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

**Илрэл нотолгоо:**

- Багшийн ажлыг Сургалт, заах арга зүйн үйл ажиллагаа, Эрдэм шинжилгээний үйл ажиллагаа, Мэргэжлийн үйл ажиллагаа, Сургууль, олон нийтийн үйлчилгээ гэсэн 4 үндсэн төрлөөр үнэлдэг.
- “ОТИС-ийн багш нарыг аттестатчилах журам”-ын дагуу жил бүр 2, 5, 11 дэх жилдээ ажиллаж буй багш нар мэргэжлийн ур чадвараа үнэлүүлж, шаардлага хангасан тохиолдолд цалингийн шатлал ахидаг. Тайлан хугацаанд ХЗС-ийн 5 багш аттестатчилалд орж цалингийн шатлал ахисан байна.
- ОТИС-ийн дотоод, хяналт, шинжилгээ үнэлгээ хийх журмын дагуу улирал тутамд Багш, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг авч, судалгааны дагуу анализ хийн хамгийн өндөр оноотой багш нар үзүүлэх хичээл зааж, хамгийн бага оноотой багш нар 3-аас доошгүй багшийн хичээлд суун туршлага судлах үүргийг хүлээдэг. Социологийн судалгаанд удаа дараа хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд хөдөлмөрийн гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авдаг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- ХЗС-ийн багш нар нь салбарын оюутнуудаас улирал тутамд авдаг багш нарын социологийн судалгааны үр дүн хангалттай сайн гэж үнэлэгддэг төдийгүй удирдлага, ажлын орчиндоо сэтгэл ханамжтай байж, тогтвор суурьшилтай ажилладаг.

**Анхаарах асуудал:**

- Багш нарын үнэлгээг оюутнуудаас авдаг социологийн судалгааны үр дүнгээр үнэлэх нь өрөөсгөл байж болох талтай
- Багш нарын өөрийн үнэлгээ болон хамт олны үнэлгээг хэрэгжүүлэх

**Зөвлөмж:**

- Социологийн судалгаандаа дүн, түүний бодит байдалд дүн шинжилгээ хийж байх

**6-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

*Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.*

**7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ОТИС нь эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулж шинэчилснээс хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалтыг хангахаар ОТИС-ийн дотоод хяналт шалгалтын журам, ОТИС-ийн дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах удирдамж, ОТИС-ийн хяналт шалгалт үнэлгээний заавар, хөтөлбөрийн хорооны журмыг боловсруулан хэрэгжүүлж байна.
- ЗХШҮА-аас хөтөлбөрт оролцогч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийдэг. Мөн хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хороо, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж хагас жил тутам, үнэлж холбогдох журмын дагуу тайлагнадаг. Энэхүү үнэлгээний хүрээнд дараах чиглэлээр мониторинг хийж дүгнэн шинжилдэг. Үүнд:
  - Суралцагч оюутан, төгсөгчдөөс авах сэтгэл ханамжийн үнэлгээ
  - Оюутны ахиц дэвшилд үе шаттай хийх явцын үнэлгээ
  - Багшийн нөөцөд хийх явцын үнэлгээ
  - Ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ буюу гүйцэтгэлийн үнэлгээ
  - Үр нөлөөний үнэлгээ /Мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх/
  - Хөтөлбөрийн санхүүгийн байдлын шинжилгээ, үнэлгээ
  - Чанарын үнэлгээ
  - Чанарын үнэлгээг судалгааны тодорхой үе шат, давтамжтайгаар хийж, үр дүнг хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сайжруулах, улирал, жилийн төлөвлөгөө, стратегийн бодлого шийдвэрт ашигладаг
- 2019 оны хичээлийн жилийн байдлаар нийт 14994 оюутан сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсанаас хууль зүйн сургууль 91.5%-ийн сэтгэл ханамжтай гэсэн үнэлгээ авсан байна.
- Багш нар бусад багш нарынхаа хичээлд сууж туршлага судлах, зөвлөгөө өгөх ажлыг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгаж үр дүнг тайланд нэгтгэн гаргадаг.
- Дотоод хяналт-шинжилгээ хийхдээ оюутан суралцагчийн санал бодлыг гол шалгуур болгодог бөгөөд жил бүр оюутнуудаас хөтөлбөрийн хэрэгжилт болон багш нэг бүрийн заах арга зүй, ур чадвар, харилцааны ёс зүй, сургуулийн бусад үйл ажиллагаатай холбоотой санал асуулгаар судалгаа авч хөтөлбөрийн хэрэгжилт болон багшийн үйл ажиллагаанд хяналт тавьж дүн шинжилгээ хийж ажилладаг. Судалгааны дүнд үндэслэн холбогдох багш, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөх мэргэжил дээшлүүлэх курс, сургалтад хамруулах, мөн сайн үнэлгээ авсан багш нарыг шагнаж урамшуулах арга хэмжээ авч ажилладаг болно.
- Хөтөлбөрөөр элсэлт авдаг болсонтой уялдуулан хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хангах зорилгоор тухайн хөтөлбөрөөр суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэгийн түвшнийг үнэлэх зорилгоор хөндлөнгийн үнэлгээ хийх ажлыг эхлүүлээд байна. Энэ ажлын хүрээнд 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн төгсөх ангийн суралцагчдаас хөтөлбөр тус бүрээр тестийн шалгалт авч дүгнэх ажил туршилт хэлбэрээр хэрэгжиж 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн тогтмол авч хэрэгжүүлж байна. Мөн сургуулийн удирдлагууд болон бусад багш нар хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын хичээлд сууж заавар зөвлөгөө өгч ажилладаг.
- Дээд боловсролын салбарын үнэ цэнийг тодорхойлох нэг чухал үзүүлэлт нь төгсөгчдийн ажил эрхлэлт байдаг. “Эрх зүйн” хөтөлбөрийн сургалт эхэлснээс хойш жил бүр төгсөгчдийнхөө хөдөлмөр эрхлэлтийн байдал, судалж, дүн шинжилгээ хийх ажил ОТИС-ийн уламжлал болсон. ОТИС нь төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг жил бүрийн 12 ба 6-р саруудад авч ХЗС дээр нэгтгэн ЗХШҮА-нд үр дүнг мэдээлдэг.
- Эрх зүй хөтөлбөрөөр төгсөгчид нь практикийн 2 жил ажилласны дараа хуульчдын сонгон шалгаруулалт өгдөг. Тухайн сонгон шалгаруулалтад тэнцсэн төгсөгчийн мэдээллийг Хуульчдын Холбооноос жил бүр гарган мэдээлдэг

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн дотоод чанарын үнэлгээний тогтолцоог үр дүнтэй хөгжүүлэх арга замыг эрэлхийлж, багш нарын уулзалт, хэлэлцүүлэг, сургалтыг тогтмолжуулсан.

- ЗХШҮА нь жил бүрийн элсэгч төгсөгчдийн шалгалтын дүнд мониторингийн шинжилгээ хийдэг нь элсэгч төгсөгчдийн чанарыг сайжруулах гол судалгаа болдог. Сүүлийн 4 жилийн элсэгчдийн шалгалтын дүнд дүн шинжилгээ хийж нэгтгэн тайлан бичсэн байна.
- MNS ISO 9001:2015 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн.
- Чанарын менежментийн тогтолцооны загвар, үйл явцын зураглал хийж ажилладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Чанарын дотоод баталгаажилтыг хангах зорилгоор гаргасан эрх зүйн баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах
- Багш нар бусад багш нарынхаа хичээлд сууж туршлага судлах, зөвөлгөө өгөх ажлыг төлөвлөгөөндөө тусгаж ажилладаг боловч үр дүнг нэгтгэж тайлагнах ажил хангалтгүй \журнал дээр тэмдэглэх төдийгөөр хязгаарлагддаг\
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог улам тодорхой болгож, үр дүнг нарийн тооцох

#### **Зөвлөмж:**

- Судалгааны асуултуудыг онол практиктай холбон үр дүнтэй болохуйц байдлаар гаргах \улиг болсон хэвшмэл, ердийн, үр дүн муутай асуултууд байгаа нь ажиглагдаж байна\
- Судалгаанд дүн шинжилгээ хийж хэвших

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны өөрчлөлт, төлөв хандлагад бодитой үнэлгээ хийх, сургуулийн дотоод хяналт шинжилгээ үнэлгээг өргөтгөх, ур чадвараа хөгжүүлэн, сургалтын чанарыг сайжруулах зорилгоор хөтөлбөрийн хороо байгуулан ажиллаж байгаа нь хөтөлбөрийн шинэчлэл хийх орчин бүрдсэн ба Сургуулийн бүтцэд ЗХШҮА ажиллаж байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд дотооддоо өөрийн үнэлгээ хийх боломжийг олгодог байна.
- Үйл ажиллагаандаа хяналт шалгалт хийж, эрсдэлд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний хяналтыг улирал тутам хийж эрсдэлийг тооцож, гарсан үр дүнгээр тодорхой ажлуудыг санаачлан хэрэгжүүлдэг байна.
- Сургалтын үйл ажиллагааны чанарыг сайжруулах чиглэлээр оюутны үнэлгээнд тулгуурлан өөрчлөлт хийн, цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган ажилладаг.
- Сэтгэл ханамжийн болон ажил эрхлэлтийн судалгааг тогтмол авч, мэдээллийн сан бүрдүүлэн цаашдын төлөвлөлт, үйл ажиллагаандаа ашигладаг байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багш нарын дунд хичээл хоорондын уялдааг сайжруулах уулзалт зохион байгуулдаг
- Хичээлийн хөтөлбөрүүд сургалтын хөтөлбөрийн зорилго зорилт, мэргэжлийн стандартад нийцэж байгаа байдалд дотоод хяналт үнэлгээ хийж хөтөлбөрөө сайжруулсан

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдөөс мэргэжлийн ур чадварын судалгаа авч хөтөлбөрийн сайжруулалтад хэрэглэдэг гэх боловч судалгааны дүн, түүнийг ашиглан хөтөлбөрөө хэрхэн сайжруулсан болохыг шууд илэрхийсэн үзүүлэлт дутмаг байв.

#### **Зөвлөмж:**

- Оюутны асуулт, түүнд хариулт заавал өгч байх тухай зорилтоо бүрэн хэрэгжүүлж төлөвшүүлэхийн тулд тодорхой журам гаргаж зохицуулах , үр дүнг тооцож байх

- Дадлагын ажлыг үргэлжлүүлэн хийдэг болсны ач холбогдол үр дүнг судлах, улмаар оюутнуудыг дадлагажуулах, хууль хэрэглээний арга дадалд сургаж төлөвшүүлэх шинэ арга, үр дүнтэй хэлбэрийг судлан ашиглаж байх

### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ОТИС нь төгсөгчдийнхөө найдвартай ажил эрхлэлт, ахисан шатны сургалт болон төгсөлтийн дараах сургалт зэрэгт анхааран ажиллаж, мөшгөх судалгаагаар дамжуулан давтан сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлагыг тодорхойлдог байна. Эдгээр судалгаанд үндэслэн гадаадын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож, багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна. ОТИС-ийн гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх асуудлыг хариуцсан нэгж ажиллаж гадаадын улс орнууд болон дотоодын бусад их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр зохион байгуулалтын ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. 2015-2016 оны хичээлийн жилээс эхлэн гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын бодлого хариуцсан дэд захирлын орон тоог шинээр бий болгон ажиллаж байна. Өмнөх магадлан итгэмжлэлээс хойш болон сүүлийн 4 жилийн хугацаанд сургуулийн хамтын ажиллагааны хүрээ нэлээд өргөжиж ахиц дэвшил гарсан гэж дүгнэж байна.
- Сүүлийн жилүүдэд тус сургуулийн 20 орчим багш давхардсан тоогоор туршлага судлах, мэргэжил дээшлүүлэх, магистр, докторын зэрэг хамгаалах, олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцох зэрэг ажлаар ОХУ, БНХАУ, Япон, Тайвань, Швейцар, БНТУ, АНУ, Ирланд, ХБНГУ, Голланд зэрэг орны их дээд сургуулиуд болон мэргэжлийн байгууллагуудтай санал солилцож ажилласан байна.
- Тайлант хугацаанд 20 гаруй оюутнууд гадаадын их дээд сургуульд ахисан түвшний сургалтад хамрагдсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаадын их дээд сургууль, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоосон багш болон суралцагч солилцоо, тэтгэлэгт болон хамтарсан сургалт судалгаа зэрэг хэлбэрээр хамтран ажилласан.

##### **Анхаарах асуудал:**

- Оюутнууд гадаадын их, дээд сургуульд ахисан түвшний сургалтад хамрагдах хүрээг аль болох өргөтгөх

**7-р шалгуурын талаарх шинжээчийн багийн нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

### НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Хангаагүй үнэлгээ өгсөн бол Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			
2	Сургалтын үйл ажиллагаа	2			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			
6	Багшийн үйл ажиллагаа	2			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	2			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлагад үндэслэн шинжээчийн баг Отгонтэнгэр их сургуулийн, Хууль зүйн сургуулийн “Эрх зүй” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул **“ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН”** гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрх зүйн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг А.Доржготов .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Г.Буянтогтох .....

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг Ч.Жаргалсайхан .....

#### IV. ЯРИЛЦЛАГАД ОРОЛЦОГЧДЫН НЭРС

##### I. БАГШ, АЖИЛТНЫ ТӨЛӨӨЛӨЛ

№	Овог нэр	Албан тушаал	Заадаг хичээл	ОТИС-д ажилласан жил
1	М.Сувд	ХЗС-ийн хувийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч	ОУ-н хувийн эрх зүйн арбитраар маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа	20
2	С.Эрдэнэболор	ХЗС-ийн нийтийн эрх зүйн тэнхимийн эрхлэгч	Захиргааны эрх зүй	14
3	Д.Наранчимэг	Багш	Иргэний эрх зүй	18
4	Ц.Алтанцэцэг	Багш	Гэр бүлийн эрх зүй	24
5	Г.Гантөмөр	Багш	Эрүүгийн эрх зүй	3
6	Р.Түвшинбат	Багш	Эрүүгийн процессын эрх зүй	9
7	Б.Энхбаяр	Багш	Иргэний процессын эрх зүй	12
8	Т.Мөнхдалай	Багш	Эрүүгийн эрх зүй	6
9	О.Хишигмөнх	Багш	Үндсэн хуулийн эрх зүй, Олон улсын эрх зүй	7
10	Н.Эрдэнэбаяр	Багш	Захиргааны эрх зүй	9
11	Б.Мөнхзаяа	Багш	Иргэний эрх зүй	4
12	Д.Даваадорж	Багш	Газрын эрх зүй	10
13	Ө.Амгалан	Багш	Эдийн засгийн онол	20
14	Д.Мөнхбаатар	Багш	Компьютер програм хангамж	15
15	Л.Одончимэг	Багш	Ерөнхий англи хэл	3
16	Б.Зоригтхүү	Багш	Мэргэжлийн англи хэл	6
17	Б.Мөнхсүлд	Багш	Биеийн тамир, эрүүл мэнд	4
18	Ж.Эрдэнэчимэг	Нягтлан бодогч		3
19	Л.Навчаа	Номын санч		15
20	Д.Хандсүрэн	Сургалтын албаны межежер		24
21	Л.Мягманхүү	Сургалтын албаны дарга		26



## II. ОЮУТНЫ ТӨЛӨЛӨЛ

№	Оюутны нэрс	Суралцдаг курс	Харьяа аймаг, хот төлөөллийн байдал	Хамрагддаг дугуйлан, клуб-төлөөллийн байдал
1	Т.Анужин	4-р	УБ хот, ажил хийдэг	Шүүхийн мэтгэлцээн клуб
2	Э.Гуамарал	4-р	УБ хот, ажил хийдэг	Клиник сургалтын төв
3	У.Лхагважаргал	4-р	УБ хот	Клиник сургалтын төв
4	Д.Мөнх-Эрдэнэ	4-р	Эрдэнэт хот, Оюутны байр	
5	М.Оюунбаатар	4-р	УБ хот	Шүүхийн мэтгэлцээн клуб
6	Б.Мичидмаа	4-р	УБ хот, гэр бүлтэй (хүүхэдтэй)	Клиник сургалтын төв
7	А.Тунгалаг	4-р	УБ хот	Оюутны холбоо
8	Б.Уянга	4-р	Эрдэнэт хот, өрөө хөлсөлж амьдардаг	Оюутны холбоо
9	Э.Баасансүрэн	3-р	Налайх хот, айлд амьдардаг	Тэтгэлэгт оюутан
10	Б.Хандармаа	3-р	Дорноговь аймаг, өрөө хөлсөлж амьдардаг	Клиник сургалтын төв
11	Д.Минжмаа	3-р	Завхан аймаг	Оюутны холбоо
12	М.Хулан	3-р	УБ хот	Клиник сургалтын төв
13	Б.Ганхөлөг	2-р	УБ хот	Клиник сургалтын төв
14	Г.Мөнгөнзаяа	2-р	УБ хот	Тэтгэлэгт оюутан
15	Т.Намуун-Эрдэнэ	2-р	УБ хот	Клиник сургалтын төв
16	Б.Эрдэнэбат	2-р	УБ хот	Клиник сургалтын төв
17	Х.Энхзул	2-р	Эрдэнэт хот, айлд амьдардаг	Оюутны зөвлөл
18	П.Буджав	2-р	УБ хот	Тэтгэлэгт оюутан
19	Б.Цэрэнмягмар	2-р	Завхан аймаг, айлд амьдардаг	Тэтгэлэгт оюутан
20	П.Зулбаяр	1-р	УБ хот	Тулах цэг клуб
21	М.Золжаргал	1-р	Завхан аймаг	Оюутны холбоо

## III. АЖИЛ ОЛГОГЧДЫН ТӨЛӨЛӨЛ

№	Овог нэрс	Ажилладаг байгууллага, албан тушаал	Холбоо барих утас
1	Г. Даваадалай	Үндсэн хуулийн Цэцийн захиргаа, удирдлагын газрын дарга	91111821
2	Д.Ганбаяр	СЗХ-Компанийн засаглал УЗ-н дарга	99007272
3	Д.Аюуш	Монгол банкны Хууль, эрх зүйн газрын дарга	99098608
4	А.Ган-Эрдэнэ	Нийслэлийн газар зохион байгуулалтын алба-хүний нөөцийн мэргэжилтэн	99085541

5	Л.Өнөртуяа	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн	91079222
6	Э.Энхболд	Инвекор ББСБ-ийн хуульч, Өмгөөллийн Богд партнерс ХХН-ийн партнер	88107766
7	З.Буяндаваа	Өмгөөллийн Time construction ХХН-н хуульч, өмгөөлөгч	99107193
8	Х.Цогзолмаа	Нотариатч (МНТ)	99109509

#### IV. ТӨГСӨГЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ

№	Овог нэрс	Төгссөн он	Ажилладаг байгууллага, албан тушаал	Утасны дугаар
1	Р.Мухийт	2003	ҮХЦ-ийн судалгааны төвийн эрхлэгч	99083407
2	Г.Дашдэмбэрэл		Монголын гол нууруудын нэгдсэн хөдөлгөөн ТББ-ын хуульч, өмгөөлөгч	99171324
3	Г.Гантуяа	2010	МӨХ-ны гишүүн, өмгөөлөгч	88059690
4	Б.Алтантулга	2011	СБД-ийн цагдаагийн 2-р хэлтэс, мөрдөгч	93010002
5	Бямбасүрэн		СБД-ийн төсвийн хэлтсийн дарга	99993330
6	Д.Амарбаясгалан	2014	ҮХЦ-ийн судлаач	95662224
7	М.Чанцалням	2015	Өмгөөллийн Ананд адвокатс ХХН-ийн өмгөөлөгч	88073524
8	Н.Энхгэрэл	2017	Жунсон констракшн ХХК-д хуулийн зөвлөх	88788750
9	Ө.Солонго	2018	БЗД, иргэний хэргийн анхан шатны шүүх, шүүгчийн туулах	89076887
10	Б.Мөнхцэцэг	2009	БЗД, иргэний хэргийн анхан шатны шүүх, хуралдааны нарийн бичгийн дарга	99603226
11	Д.Болормаа	2015	Лега полиси ХХН-ийн хуульч өмгөөлөгч	99994947
12	Д.Ганбат	2016	Хүнс комплекс, Батзуурмаг, Монгол дизель ХХК-ийн хуулийн зөвлөх	99998648

**ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) ..... [Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

**ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) ..... [Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**